

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМААС
БИНДЭР СУМ РУУ ТАВИХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ
115 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН
ТРАССЫН ДАГУУХ ТАЛБАЙ**

Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан

Тайлан бичсэн: Б.ЦОГТБААТАР - Археологийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
доктор (Ph.D), профессор

Г.ЛХҮНДЭВ - Археологийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Э.АМАРБОЛД - Археологийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Захиалагч байгууллага: “Эм Си Пи Си Жи Ар” ХХК

Тайлан өмчлөгч: Археологийн хүрээлэн.
Улаанбаатар-13343, Жуковын гудамж-77
ШУА-ийн Нэгдсэн I байр
Утас: 11-452894, факс: 976-11-458305
Э-хаяг: archaeology@mas.ac.mn

**УЛААНБААТАР
2021**

Бүртгэлийн дугаар

Нууцын зэрэглэл: . . .

Гэрээний дугаар: . . .

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМААС
БИНДЭР СУМ РУУ ТАВИХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ
115 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН
ТРАССЫН ДАГУУХ ТАЛБАЙ**

Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан

Тайлан бичсэн:

Б.ЦОГТБААТАР - Археологийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
доктор (Ph.D), профессор

Г.ЛХҮНДЭВ - Археологийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Э.АМАРБОЛД - Археологийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Захиалагч байгууллага:

“Эм Си Пи Си Жи Ар” ХХК

Тайлан өмчлөгч:

Археологийн хүрээлэн.
Улаанбаатар-13343, Жуковын гудамж-77
ШУА-ийн Нэгдсэн I байр
Утас: 11-452894, факс: 976-11-458305
Э-хаяг: archaeology@mas.ac.mn

9019090235 ☎ 6471072

**УЛААНБААТАР
2021**

Гарчиг

Удиртгал	5
1. Судалгааны байдал	6
1.1. Хэнтий аймгийн нутагт хийсэн археологийн судалгаа	6
1.2. Монголын археологийн үечлэл, товч тойм	15
1.3.a. Чулуун зэвсгийн үе	15
1.3.b. Хүрэл зэвсгийн үе	17
1.3.c. Эртний улсуудын үе	19
1.3.d. Дундад зууны үе	22
2. Судалгааны ажлын түүх	25
2.1. Хээрийн судалгаа хийх болсон хууль, эрхзүйн үндэс	25
2.2. Хээрийн судалгааг хийх болсон шалтгаан, зорилго, ажлын төлөвлөгөө	26
3. Хайгуул судалгаа	27
3.1. Арга зүй, аргачлал	27
3.2. Дурсгалын баримтжуулалт	28
3.3. Хайгуул судалгааны ажлын тодорхойлолт	31
Дурсгал-01	31
Дурсгал-02	32
Дурсгал-03	33
Дурсгал-04	34
Дурсгал-05	35
Дурсгал-06	36
Дурсгал-07	37
Дурсгал-08	38
Дурсгал-09	39
Дурсгал-10	40
Дурсгал-11	41
Дурсгал-12	42
Дурсгал-13	43
Дурсгал-14	44
Дурсгал-15	45
Дурсгал-16	46
Дурсгал-17	47
Дурсгал-18	48
Дурсгал-19	49
Дурсгал-20	50
Дурсгал-21	51
Дурсгал-22	52
Дурсгал-23	53
Дурсгал-24	54
Дурсгал-25	55

Дурсгал-26	56
Дурсгал-27	57
Дурсгал-28	58
Дурсгал-29	59
Дурсгал-30	60
Дурсгал-31	61
Дурсгал-32	62
Дурсгал-33	63
Дурсгал-34	64
Дурсгал-35	65
Дурсгал-36	66
Дурсгал-37	67
Дурсгал-38	68
Дурсгал-39	69
Дурсгал-40	70
Дурсгал-41	71
3.3. Хайгуулаар илрүүлсэн дурсгалын товч мэдээлэл	72
3.4. Дурсгалын тархалтын зураг	74
4. Хэнтий аймгийн нутаг дахь түүхэн дурсгалт газруудын товч танилцуулга	76
5. Судалгааны ажлын товч үр дүн.	91
6. Ном зүй.	94

Удиртгал

“Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн 372/21 тоот судалгаа хийлгүүлэх хүсэлт, ажил гүйцэтгэх №Б/2021-34 тоот гэрээний хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй 115 км (А хувилбар) хатуу хучилттай авто замын трассын дагуу археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг /археологийн дурсгалыг бүртгэж баримтжуулах/ 2021 оны 10 дугаар сарын 27-ноос 30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааны багт тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Б.Цогтбаатар, эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Г.Лхүндэв, магистр Э.Амарболд, жолооч Б.Валя нар оролцон ажиллав.

Хээрийн судалгаа нь доорх хууль журмын заалтыг даган мөрдөх тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэв. Үүнд, “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан байдаг. Мөн түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль бий. Энэхүү хуулийн (шинэчлэн найруулсан) 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-т “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах”, тус зүйлийн 9-т “Урьдчилсан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна” хэмээн тус тус заасан байдаг.

Мөн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор БСШУ-ны сайдын 2015 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/141 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн судалгаа хийх журам”-ын 2.1.2-т “авран хамгаалах судалгаа” гэж байгаль орчны өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаанд өртөн эвдэрч, устах эрсдэлд орсон дурсгалыг хамгаалах болон газрын хэвлийг ашиглахаас өмнө захиалагчийн хүсэлтийн дагуу гүйцэтгэх палеонтологи, археологийн хайгуул судалгааны ажлыг хэмээн тодорхойлсон байна.

1. Судалгааны байдал

1.1. Хэнтий аймгийн нутагт хийсэн археологийн судалгааны тойм

Хэнтий аймаг нь 1930 онд байгуулагдсан бөгөөд 21 аймгаас 9-р бичигдэх 80,311 км² газар нутагтай, 2008 оны тоогоор 67,770 хүн амтай, 17 сумаас бүрдэх манай зүүн бүсийн томоохон засаг захиргааны нэгж юм. Аймгийн газар нутгийн ихэнх нь тал хээр ба хойд талаар модтой уулсаар хүрээлэгджээ. Эзэн богд Чингис хааны төрж өссөн нутаг, монголчуудын уугуул газар шороо тул дотоодын төдийгүй гадаадын судлаачдын анхааралд их өртөж, эртнээс судалгаа шинжилгээний ажил хийгдэж иржээ. Бидэнд байгаа материалд тулгуурлавал Хэнтий аймгийн нутагт анхны археологийн чиглэлийн судалгааг 1926 онд Зөвлөлтийн судлаач С.Кондратьев хийж, энэ чиглэлийн судалгааны шанг татжээ. Тэрээр Хэнтий аймгийн нутагт байх Өглөгчийн хэрмийг хайгуулын журмаар судлан үзэж, дэвсгэр зургийг үйлдсэн байна [Кондратьев, 1926]. Энэ нь чулуу өрж шавар наалтгүйгээр уул түшүүлэн барьсан түр зуурын байдалтай хэрэм бөгөөд тэндээс олдсон шавар савны хагархайн байдалд түшиглэн Х.Пэрлээ Хятаны үед холбогдоно гэж он цагийг тодорхойлжээ [Пэрлээ, 1959, 87].

Өглөгчийн хэрэмд барилга байсан ор улбаа байхгүй бөгөөд хэрмийн дотор хананд тулган шороон дэвсэг нэмж тэгшилснээс үндэслэж С.Кондратьев XII-XIV зууны үеийн нум сумчдын бэхлэлт байсан болов уу гэж үзсэн тал бий. Харин түүхч Х.Пэрлээ тэндээс олдсон олдвор шавар савны хагархайнуудаар баримжаалж Хятаны үед холбогдоно гэж тогтоожээ [Пэрлээ, 1961].

1927 онд Зөвлөлтийн судлаач А.А.Амстердамская одоогийн Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотын орчимд буй, нутгийн ард олон "Гэлэн чулуу" хэмээн нэрлэдэг, Дарьгангынхтай адил сандалд суулган дүрсэлсэн нэгэн хүн чулууг үзэж тодорхойлон бичсэн ба маш чадмаг үйлдсэн гар зургийг өдрийн тэмдэглэлдээ хавсарган үлдээжээ [Амстердамская, 1927].

Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэр уулын зүүн урд хормойн цохиотой үзүүрийг Рашаан хад гэнэ. Рашаан хадны орчмыг археологийн талаар судлах ажлын эхлэлийг доктор Х.Пэрлээ 1942 онд анх тавьсан бөгөөд 1960-1980 онд бараг жил бүр очиж судалгаа хийж олдвор хэрэглэгдэхүүндээ тулгуулан эрдэм шинжилгээний ба нийтлэг өгүүлэл 10 орчмыг бичиж нийтэлсний гадна, хаднаа сийлсэн тамгыг судалж ганц сэдэвт зохиол туурвисан билээ.

1949 онд С.В.Киселевын үндэс суурийг нь тавьсан Монгол-Зөвлөлтийн түүх-угсаатны зүйн хамтарсан экспедицийн чулуун зэвсэг судлах анги Хэрлэн голын саваас палеолитын үеийн зэвсэг нэлээдийг түүвэрлэжээ [Ларичев, 1958]. Мөн онд К.В.Вяткинагийн удирдсан угсаатны зүйн анги Хэнтий аймгийн Биндэр сумын Биндэр уул, Дорнод аймгийн Хэрлэнбаян сумын нутаг Хэрлэн голын баруун эрэг хавиас цөөн тооны дээд палеолитын үед холбогдох зэвсэг олжээ [Вяткина, 1958].

1948-1949 онд ЗХУ-ын ШУА-ийн Түүх-Угсаатны зүйн экспедицийн этнографийн анги Хэнтий аймгийн Дунд Жаргалантын гол, Төв аймгийн

Мөнгөнморьт сумын нутаг Наран толгой зэрэг газраас хэд хэдэн буган хөшөө илрүүлснийг К.В. Вяткина хожим нийтэлжээ [Вяткина, 1959, 99-103].

Их Монгол улсын нийслэл Хархорум хотын туурийг 1948-1949 онд малтан шинжлэх ажлыг гүйцэтгэсэн ЗХУ-ын ШУА болон Монголын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хамтарсан том экспедицийн К.В. Вяткина ахлагчтай угсаатны зүйн анги манай орны нутгийн баруунаас зүүн тийш хөндлөн туулан арав гаруй мянган км-ийн их аян хийж эртний судлал, угсаатны зүйн арвин олдвор, мэдээ баримт цуглуулсны дотор хүн чулуун хөшөөний зүйлс багагүй бий [Вяткина, 1959].

Зүүн зүг зорьсон аяллынхаа үед Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг бололтой Наран хэмээх газарт 1 хүн чулуу, Батхаан уулын хормой, Таван толгой хэмээх газарт нутгийнхан "Чингисийн тулга" гэж ярьдаг цэцгэн хээ бүхий хавтант хашлага, Жаргалтхаан (Жаргалан хаан гэж бичжээ) сумын төвөөс зүүн тийш 10 км зайтай Бархи Жаргалант гэдэг газарт нэгэн хүн чулуу зэрэг урьд өмнө мэдэгдээгүй дурсгалуудыг үзэж тэмдэглэн гар болон гэрэл зургийг нь хавсарган нийтлүүлсэн байна.

Хэнтий аймгийн Дадал сумын нутаг Түхнэн уулын хадны хөмөгт байсан эртний оршуулгыг нутгийн хүмүүс сүйтгэсэн (1932 онд) мэдээллийн мөрөөр 1949 онд оюутан Гомбожавыг тусгайлан томилж эд өлгийн зүйлийн үлдэгдлийг Улаанбаатарт авчруулан судалсан явдал мөн. Түхнэн уулын хадны оршуулгаас мод матаж хоёр үзүүрийг нь зөрүүлэн боосон сонин хийцтэй дөрөө бүхий эмээл унуулан суулгаж, биеийг нь эсгийд боож тавьсан эмэгтэй хүний занданшуулсан шарил илэрсэн байна. Шарилын толгойд 12 зүйлийн ангийн үсээр хийсэн, бас унжлага залаа ба хоёр төмөр цагираг хадсан оргой малгай өмсгөсөн бөгөөд биед нь хуучин цагийн бүдүүн ширхэгтэй цэнхэр даавуу дээлийн тамтаг үлдсэн байжээ. Хүний хөлд нэхийгээр хийсэн ээтэн сөөхий гутал, эсгий оймс байсны зэрэгцээ чихэнд нь гуулин ээмэг, хүзүүнд нь гурван зүйл өлбөн чондор зүүлгээстэй байжээ. Энэ дурсгалын тухай товч тэмдэглэлийг Монголын археологич Х.Пэрлээ бичиж, хүний яриагаар сэргээж зурсан тойм зургийн хамт 1959 онд "Studia Mongolica" цувралын анхны дугаарт хэвлүүлсэн байна [Пэрлээ, 1959б]. Харин олдворын зүйлсийг Зөвлөлтийн судлаачид тухайн үеийн Ленинград хот руу авч явсан нь одоо сураггүй болжээ.

1952-1953 онд Х.Пэрлээ Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг Хэрлэнгийн Баянцог овоо, Батширээт сумын Өглөгчийн хэрэмний орчмоос таргил үлдэц, үзүүр мэс, хянгар, хусуурууд, Рашаан хаднаас цахиураар хийсэн үзүүр мэс, цүүц зэрэг дунд, дээд палеолтын үед холбогдох зэвсгийн зүйл олсны заримыг [Доржсүрэн, 1957] нийтэлжээ. 1961 онд Х.Пэрлээ, Шуберт нарын удирдсан Монгол-Германы хамтарсан археологи-угсаатны зүйн шинжилгээний анги Хэнтий аймгийн чиглэлд ажилласан бөгөөд Онон, Балж голын эрэг хавиас палеолит, неолитын үеийн зэвсгийн зүйлс олдсоныг тус ангид оролцсон Германы археологич Дитрих Маниа урьд өмнө цуглуулсан зарим олдворын хамт нийтэлжээ [Mania, 1963].

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт зэрэгцээ хоёр хэрэм байдгийг археологич Х.Пэрлээ 1952-1953 оны хооронд малтан шинжилжээ [Пэрлээ, 1957; Пэрлээ, 1957а].

1952 онд Х. Пэрлээ Хэнтий аймгийн Баянмөнх сумын Баянцогт овоо, Төв аймгийн Мөнгөнморьт сумын Сүүжийн булаг зэрэг газруудад арваад дөрвөлжин булш малтан шинжилж МЭӨ VII-V зуунд холбогдуулан үзжээ [Пэрлээ, 1957].

Хэнтий аймгийн Хэнтий сумын нутаг Навчитын голын ойр Төгсийн өвдөг гэдэг газарт Х. Пэрлээ 1957 онд түрэг булш малтжээ. Тэнд нэг дор цуварсан гурван булш байжээ. Бүгд балбал буюу зэл чулуутай боловч тус бүрд чухам хэд байсныг тодорхойлоход бэрхшээлтэй болсон байжээ [Сэр-Оджав, 1970, 25].

1960-1970-аад онд Д. Наваан Зөвлөлтийн болон Унгарын археологчдын хамт Дорнод аймгийн Гурванзагал сумын Цагаан чулуут, Хэнтий аймгийн Дуулга уул, Өвөрхангай аймгийн Ховд багийн Тэвш уул, Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хутаг уул, мөн Салхит өртөөний орчим хүннү булш малтжээ. Мөн Дархан хотын ойролцоо газар шорооны ажлын явцад эвдэрсэн 6 булшийг Х.Пэрлээ нар малтан судалжээ [Гришин, 1978, 95-100].

1961 онд байгуулагдсан БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи, тэр үеийн Ардчилсан Герман улсын Халле-Виттенбергийн Мартин-Лютер Их Сургуультай хамтран ажиллах тохиролцоонд хүрсний үрээр мөн онд Монгол-Германы хамтарсан археологийн шинжилгээний анги (Монголын талаас: БНМАУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн Х.Пэрлээ, Германы талаас: БНАГУ-ын эрдэмтэн, профессор И.Шуберт, археологич Д.Маниа) тус улсын Хэнтий аймгийн нутгаар хайгуул, судалгааны ажил хийж Чингис хааны булшийг хадгалсан Бурхан Халдун уулыг эрсэн ба Дэлгэрхаан сумын нутаг Аваргын голын Рашаан дэрсний балгас, Хэнтий Хан уулын дунд овооны дэргэд Дээд тахилга гэдэг XIII-XIV зууны үеийн барилгын ор үлдцийг судалсан байна [Пэрлээ, 1962а, 69-72; Schubert, 1963; Mania, 1963, 847-888; Schubert, 1966, 235-247].

1961 онд манай улсын нэрт археологич Х.Пэрлээ анх илрүүлэн олж, он цагийг урьдчилан тогтоосон Аваргын балгас хэмээх эртний хотын турь нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших бөгөөд 2001 оноос Монгол-Японы хамтарсан шинжилгээний анги малтлага судалгаа хийж байгаа нь уг суурины холбогдох он цаг, үүрэг зориулалт хийгээд Монголын түүхийн сурвалж бичгийн мэдээтэй хэрхэн холбогдох зэргийг нягталж, энэхүү дурсгалт газрын талаархи түүхэн мэдлэгийг улам гүнзгийрүүлэн тодруулахад нэн чухал ач холбогдолтой судалгаа болж байна [Цогтбаатар. 2004].

Монголын үеийн булшны хэрэглэгдэхүүн цуглуулах, түүний төрөл зүйл, хүрээ хэмжээ, тархалтыг тогтооход анхаарсан үе. 1960-аад оны дунд үеэс 1980-аад оны сүүл хугацааг хамарна. Эхэн үед судалгааг Онон, Хэрлэн, Туул гурван голын сав нутагт төвлөрүүлэн явуулах оролдлого хийгдсэн бөгөөд Х.Пэрлээ, Д.Наваан нарын судлаачид Монгол орны зүүн талын аймгуудад олон сараар хээрийн шинжилгээ хийсэн байна. Энэ үед гол төлөв өөр зорилго чиглэлтэй хээрийн шинжилгээний явцад энд тэнд монгол булшийг цөөн тоогоор малтахын

зэрэгцээ 1982-1984 онд Сэлэнгэ аймгийн Хонгор сумын Буурал уул, 1987-1989 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Бурхан толгой, Ханан, Долоод зэрэг монголын үеийн оршуулгын газрыг малтан судалжээ.

1966 онд “Гурван голын” шинжилгээний анги (Д. Наваан) Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Аваргын голын Рашаан дэрсэнд хоёр [Наваан, 1966, 7-8], 1968 онд гурав, мөн сумын Долоод хэмээх газар хоёр, Дадал сумын төвд нэг, Батширээт сумын нутаг Бархын голын савд тав [Лхагвасурэн, 1994, 73-74], 1969 онд Дэлгэрхаан сумын Рашаан дэрсэнд нэг, нийт 14 булш малтаж хувцас хунар, зэр зэвсгийн үлдэгдэл, мал амьтны яс илрүүлэн XIII-XIV зууны үед холбогдуулан үзжээ [Наваан, 1968, 14-15, 22, 24, 32]. Гэвч дээрх ангийн малтан судалсан монгол булшны үнэмлэхүй он цагийг нягтлан тогтоосон нийтлэл одоо хүртэл гараагүй байна.

1966-1969 онд Д. Наваан Хэнтий аймгийн Аваргын голын Рашаан дэрс, 1976-1980 онд Н. Сэр-Оджав, Д. Баяр нар Хархорумын дэргэдэх хотын оршин суугчдын булш оршуулгыг илрүүлэн судлахад чухал хувь нэмэр оруулжээ.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Төгс Өндөр хэмээх уулын өмнүүр урсах Жаргалант, Чандмань голын бэлчирийн хойдох зэрэгцээ гурван булшийг 1967 онд малтан судалжээ. Эдгээр булш цөм дөрвөлжин хэлбэртэй бөгөөд хавтгай нимгэн чулууны дээд ирмэгийг шугамдсан мэт тэгшхэн цухуйлган зоож хашлагыг үйлджээ. Наран ургах зүгт чулуу зэллүүлж балбал босгожээ. Иймэрхүү булшийг гадаад байдлаар нь Түрэгийн үеийн гэж судлаачид үздэг боловч, дотоод зохион байгуулалт, зан үйлийн хувьд өвөрмөц юм.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг хуучин Хэнтий сумын төвийн ойролцоо Хурх Жаргалантын боомоос баруун хойно хүн дүрст хөшөө бүхий бүлэг булш бий. Сайн ажиглавал, эхний бүлэг дөрвөн булш нь хос хосоороо байдалтай. Эдгээр булшны чулуун хөшөөдийг бараг засалгүй хийжээ. Энд 1967 онд гурван голын шинжилгээний ангийнхан дөрвөн булш малтан шинжилсэн.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Хурхын голын хөндийгөөр олон үеийн булш дурсгал ихтэй бөгөөд хуучин Хэнтий сумын төвөөс зүүн урагш Дээд-Өлзийт уулын баруун хойд ар бэлд 24 дөрвөлжин булш нэг дор бий. Энд анх 1968 онд Гурван голын шинжилгээний ангийнхан 14 булш малтан судалжээ. Угсаатны зүйч Л.Л.Викторова 1967-1969 онд Монголын дорнод нутгаар угсаатны зүйн судалгааны ажлаар явахдаа Дорнод аймгийн Халх гол сумын Шонх таван толгой, Матад сум, Хэнтийн Өндөрхааны орчимд буй, нийт 5 хүн чулууг угсаатны зүйн үүднээс судлан үзэж, тэдгээрийн дээл хувцас, гээг үсний хэлбэр төрхөөс үндэслэн XIII-XIV зууны монголчуудын дурсгал гэж үзэж буйгаа уг бүтээлдээ дурджээ [Викторова, 1980, 39].

Х.Пэрлээ 1967 онд Хэнтий аймгийн Хэнтий сумын нутаг Хурх, Жаргалантын голд судалгааны ажил гүйцэтгэхдээ Төгсийн өвдөг, Хурхын улаан эрэгнээс доош, Хурх, Жаргалантын боом, Төгсийн булгийн адаг, Жаргалантын голын хойно гэхчлэн хэд хэдэн газарт хашлага чулуу, балбал (зэл чулуу), зарим нь хүн чулуу бүхий, түрэгийн үед хамааруулан үздэг чулуун байгууламж хорь гаруйг малтан

шинжлээд эдгээр нь хятаны үеийн булш оршуулга байж болох талаар шинэ санаа дэвшүүлжээ.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга ууланд буй 142 булшнаас 1969 онд Д.Наваан, И. Эрдели нар цөөн хэдийг (Наваан, 1969), 1975 онд Д.Баяр нэгийг [Баяр, 1976, 60-65], 1988 онд Д. Цэвээндорж, И. Эрдели нар таван булш тус тус малтсан байна [Erdelyi, Tseveendorj, 1994, 63-69].

1963 онд Х.Пэрлээ, Л.Ийсл нар Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хадны тамга, зургийг судалжээ [Пэрлээ, 1976].

1969 онд Д. Наваан хээрийн шинжилгээний ажлын явцад Дорнод аймгийн Гурванзагал сумын Цагаан чулуут, Хөлөнбуйр сумын Өлзийт, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Рашаан Дэрс, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ховд ууланд тус бүр нэг, нийт 4 булш малтаж, дундад зууны монголчуудын өмсөж эдлэж байсан дээл, малгай, гутлын үлдэгдэл зэрэг онц чухал хэрэглэгдэхүүн илрүүлсэн байна [Наваан, 1969, 23-24, 26-28]. Гэвч малтлагын зураглал, баримтжуулалт зохих шаардлагын дагуу хийгдээгүй, булшны материал одоо болтол нийтлэгдээгүйн дээр олдворуудыг ч зохих нөхцлийн дор хадгалж байгаагүйгээс болж ихэнх нь гэмтэж үрэгдсэн ажээ.

Монгол орны нутгаас олдсон палеолитын үеийн соёлт давхарга бүхий томоохон суурин болох Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дахь Рашаан хадны сууринг Х.Пэрлээгийн удирдсан Гурван голын шинжилгээний анги 1973, 1974 онуудад туршилтын журмаар малтсан [Цэвээндорж, 1988] бөгөөд 1980 онд А.П.Окладников, Д.Дорж, 1981 онд Р.С.Васильевский, Д.Цэвээвдорж нарын удирдлагаар МЗТСХЭ-ийн палеолитын дурсгал судлах анги үргэлжлүүлэн малтан судлах ажлыг гүйцэтгэсэн юм [Окладников, Васильевский 1982].

Унгар улсын эртний судлаач И.Эрдели 1971 онд Хэнтий аймгийн Өндөрхаан хотын дэргэд буй "Гэлэн чулуу" хэмээх сандалт хүн чулууг судлан гэрэл зураг, тодорхойлолт нийтлүүлэн Дорнод Монголын сандалт хүн чулуудын он цагийн талаар Н. Сэр-Оджавын дэвшүүлсэн бүр хожуу үед холбогдоно гэсэн саналыг дэмжиж буйгаа илэрхийлж, дээрх дурсгалууд нь Монголын хожуу үед, бүр XVII зууны үед ч холбогдож болохыг үгүйсгэхгүй гэжээ [Erdelyi, 1977, 203-217].

МЗТСХЭ-ийн гишүүн Ю.С.Худяков 1979-1982 онд, Монгол нутагт өргөн хэмжээтэй тархсан түрэгийн үеийн чулуун хашлагат тахилын онгонуудыг тусгайлан судлах ажил гүйцэтгэж, Туул голын эхэн сав нутгийн Дуганы хөтөл, Их Дэндий, Морин даваа, Тулгат гацаа, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хангал гол, Архангай аймгийн Тариат сумын нутаг Тэрхийн цагаан нуурын дэргэдэх Дадгын өвөлжөө, Нарийн хоолой зэрэг газарт буй чулуун хашлагуудыг судалсны үндсэнд түрэгийн үеийн "эгэл жирийн" хэмээгдэх тахилын онгоны байгууламжийн ангилал гаргаж, Дадга, Нарийн хоолойн хүн чулуун хөшөөдийг судлан нийтлүүлжээ [Худяков, 1985].

1976 онд "Говийн экспедици" (Д.Наваан) Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Чандаган талын нүүрсний ил уурхайн ашиглалтын талбайд орсон дөрвөн булш, Жаргалтхаан сумын Залаа хэмээх газар нэг, Дорноговь аймгийн Алтанширээ

сумын төвийн баруун урдах Хадат толгойн энгэрт нэг, Хар Аарагт хоёр [Наваан, 1976а, 7-9, 12], Увс аймгийн Зүүнговь сумын нутаг Саран толгойн энгэрт нэг булш [Наваан, 1976б, 74], нийт 9 булш малтан шинжилжээ. Эдгээрээс зарим булшны маш товч тодорхойлолтыг Д.Наваан 1986 онд хавсралт зураггүй нийтэлсэн.

МЗТСХЭ-ийн хүрэл ба төмөр зэвсгийн дурсгал судлах анги 1976-1983 онд Хэнтий аймгийн Мөрөн сумын Чандаган тал, Буянт сумын Буянтын чулуу, Дорноговь аймгийн Алтанширээ сумын төв орчим, Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Хан хад, Архангай аймгийн Батцэнгэл сумын Шивэртийн ам, Эрдэнэмандал сумын нутаг Хөшөөн тал, Төв аймгийн Алтанбулаг сумын Тариат багийн Алтанцэцэг, Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай уул, Зүйл сумын Наран толгой, Булган аймгийн Бүрэгхангай сумын Зараа толгой, Төв аймгийн Алтанбулаг сумын Бурхантайн гацаа зэрэг нутагт 50 орчим дөрвөлжин булш малтан шинжилж [Наваан, хувийн архивт] сувс, оюу зүүлт, алтан ээмэг, шавар савны хагархай, ясан эдлэл, малын яс зэрэг шинжилгээний хэрэглэгдэхүүн олжээ.

1985 онд Д.Наваан Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулуунд хадны оршуулга хоёр, Улаанбаатар хотын Гачуурт дүүргийн Их аманд чулуун овоолгот булш хоёр, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Орвон ууланд нэг булш [Наваан, 1985, 4, 7, 9], 1986 онд Д.Наваан, Х.Лхагвасүрэн нар Хэнтий аймгийн Орвон ууланд гурав, нийт 8 булш малтжээ [Лхагвасүрэн, 1994, 67, 70]. Булшны материал нийтлэгдээгүй.

1986 онд Хэнтий аймгийн нутагт ажилласан ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн "Палеоэтнографийн анги" (Г.Мэнэс) Дэлгэрхаан сумын Хүйтэн хошуу хэмээх газар хадны нэгэн оршуулга малтан шинжилж, гэрийн хананд хавсарч тавьсан хүний яс, шибэлгэр гэзэг, гуулин товч, мөнгөн ээмэг, арьсан гутлын үлдэгдэл, өвөрмөц хийцтэй модон эмээл зэрэг сонирхолтой олдвор илрүүлжээ [Мэнэс, 1986а, 26-32]. Энэ бол манай орон дахь дундад зууны хадны оршуулгын дотроос судлаачдын гарт бүрэн бүтнээр хүрч ирсэн анхны дурсгал болох төдийгүй шинжлэх ухааны зохих түвшинд баримтжуулалт үйлдэн судалсан анхны ажил байсан [Мэнэс, 1988б, 24-25; Мэнэс, Билэгт, 1992, 155-159]. Булшны товч тодорхойлолтыг Г. Мэнэс 1988 онд хавсралт зургийн хамт орос хэлээр нийтлэжээ.

1987 онд археологич Г.Мэнэс Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Ханан хэмээх газар чулуун овоолгот булш дөрөв, хадны оршуулга нэг [Мэнэс, 1987а], 1988 онд Дэлгэрхаан сумын Бурхан толгойд зургаан булш, Хананд хадны гурван оршуулга [Мэнэс, 1988а], 1989 онд Дэлгэрхаан сумын нутаг Долоодод тав, Дунд Ханан, Хар Үзүүрт тус бүр нэг, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Чимэгт овоо гэдэг газар нэг булш [Мэнэс, 1989] малтан шинжилжээ. Дээрхи "Палеоэтнографийн анги" язгуурын монголчуудын голомт нутаг Гурван голын савд монгол булшны талаар нилээд ултай судалгаа хийж эхэлсэн боловч дөрөв таван жилийн дараа хаагдсанаас гадна судалгааны эх хэрэглэгдэхүүн нь одоо болтол хэвлэн нийтлэгдээгүй байна.

1990-1994 онд Чингис хааны онгоныг хайх “Гурван гол” Монгол-Японы хамтарсан төслийн хүрээнд явуулсан археологийн хайгуулын анги Хэнтий хан уулын орчимд Чингис хааныг оршуулсан байж болох газар, мөн Чингис хааны өвөг дээдсийг оршуулсан “Ихэсийн газар” буюу “Их Өтөг”, бас Чингис хааны дараах Монголын зарим их ба бага хаадыг оршуулсан “Их Хориг”-ийг байж болох болов уу гэж үзэж товлосон газарт археологийн ямар нэгэн дурсгал, булш бунхан байгаа эсэхийг шалгаж, талбай сонгон геофизикийн шинжилгээ хийсэн байна. Мөн Төв аймгийн Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын нутагт хайгуулын ажлын үр дүнд археологийн олон дурсгал илрүүлэн олж судалгаанд хамрагдсан газар усны нэрийг тодруулан газрын зурагт тэмдэглэжээ [Gurvan Gol, 1990; Gurvan Gol 1994; Бадамхатан, 1997].

Тус шинжилгээний анги нь судалгааны ажлаа дараагийн жилүүдэд үргэлжлүүлэн 1991 онд Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Баян-Адрага, 1992 онд Өмнөдэлгэр, Дэлгэрхаан сумдын нутагт гүйцэтгэж, эхний жил 191, дараагийн жил 227 тооны түрэгийн үеийн тахилын онгоны дурсгал илрүүлсэн юм. Биндэр сумын Улаан үзүүр, Өмнөдэлгэр сумын Тахилгат хад, Дэлгэрхаан сумын Хөшөөтийн хүр, Гүн бүрд зэрэг газруудад нийт 10 хүн чулуу илрүүлэн олж тэмдэглэсэн болно [Gurvan Gol, 1994, p. 5-6].

1990-1993 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд оролцсон археологичид Хэнтийн нурууны салбар уулс, Хэрлэн, Онон голын сав газраас шинэ суурингуудыг илрүүлэн [A report..., 1999] олон тооны чулуун зэвсэг түүвэрлэсний нэлээд хувь нь палеолитын үеийн зэвсгийн зүйлс байна [Гурван гол, 1990, 1991, 1992]. Үүнд, 1990 онд Хэрлэн голын эхэн урсгалын баруун эрэг дагуу, Богдын голоос дээш Хөшийн гол, Баруун Бүрхийн голын дунд орших Намсрайн овоо (ухаа)-ны орчим, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нугаг Номгон уулын энгэрээс баргил залтас, хянгар маягийн зэвсэг, Хэрлэн голын баруун эрэг, Зүүн Байдлагийн гол, Тогос уул, Сангайн ам, Сүүжийн дэнж, Номгон толгой, Зорголын шар хад, Хустын булаг зэрэг газраас палеолитын үед холбогдох баргил залтас, дугуй үдцэц, хусуур, үзүүр мэс, гилбэр маягийн эдлэл нэлээд хэмжээгээр олджээ.

1991 онд тус шинжилгээний ангийнхан Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын нугаг Онон, Хурхын голын сав газарт ажиллах далимдаа чулуун зэвсгийн зүйлс цуглуулснаас Батширээт сумын нугаг Онон голын сав Ёлын байц, Биндэрийн Рашаан хад, Асгат уулын энгэр, Өглөгчийн үзүүр, Ганц модны жалга зэрэг газраас олдсон баргил хянгар, хусуур, залгсан хусуур, дугуй үлцэц зэрэг олон эдлэл нь палеолитын үед холбогдоно [Гурвангол, 1991].

1991 оноос Монгол, БНСУ-ын эрдэмтдийн хамтарсан “Дорнод Монгол” төсөл анхны үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 1992-1995 онд Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгуудын нутгаар хуучин ба шинэ чулуун зэвсэг, хүрлийн болон дундад зууны эд өлгийн дурсгал, түүх, угсаатны зүйн судалгааны ажил гүйцэтгэсэн байна.

1992-1993 онд дээрх шинжилгээний анги Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумдын нутгаар хайгуул судалгааны ажил гүйцэтгэх явцдаа Хэрлэнбаян-Улаан уулын салбар Бугахайрхан, Их Хайлант, Шар хад зэрэг газраас палеолитын үеийн чулуун зэвсгийн зүйлс нэлээд хэмжээгээр цуглуулснаас гадна Дэлгэрхаан сумын төвөөс баруун урагш 20-иад км-т, Хэрлэн голын зүүн биенд орших Ханангийн энгэрийн палеолитын дурсгалт газрыг илрүүлэн олсон [Цогтбаатар, 1994] юм.

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Хэрлэн голын дээд гүүрнээс зүүн тийш 5 км зайд Устын ам хэмээх газарт хоёр хиригсүүр, их бага нийлсэн арван дөрвөлжин булш, зургаан жижиг дугуй булш бий. 1993 онд Монгол, Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний ангийнхны хийсэн хайгуулын явцад эдгээр дурсгалын байршил зүйн зургийг үйлдэж, тодорхойлолт хийснээс гадна нэгэн булшийг сонгон авч малтан судалжээ.

1993-1995 онд Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний ангиин судлаачид Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Сүхбаатар аймгийн Дарьганга сумдын нутгаар хайгуул болон туршилтын малтлага хийж, олон тооны чулуун зэвсэг илрүүлжээ [Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ 2, 3, 4]. Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн судлаачид 1998 онд Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн голд малтлага хийж, хайгуулын явцад Рашаан хад, Биндэр нуур орчмоос олон арван чулуун зэвсгийн зүйлс илрүүлсний зэрэгцээ Биндэр сумын нутаг Өргөн нарс, Бор булгийн ам зэрэг газраас палеолитын үеийн шинэ оддворууд цуглуулсан [Uglugchingol Site, 1999] байна.

2002 онд Д. Наваан Монгол-Америкийн хамтарсан “Чингис хаан” экспедицид ажиллахдаа Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн хэрмийн ойролцоо монголын үед холбогдох эгэл ардын чулуун овоолгот булш нэгийг ухаж хазаарын төмөр цагираг, дөрөө зэрэг олдвор олсон ажээ [Наваан, 2002, 1; Өлзийбаяр, Дэмчигдонров, 2002, 8-12]. Уг булшны малтлагын товч тайланг С.Өлзийбаяр 2003 онд МУИС-ийн эрдэм шинжилгээний бичигт нийтлүүлжээ [Өлзийбаяр, 2003, 76-81].

2003 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэнгийн Хөдөө аралд хайгуул судалгаа явуулсан Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги Ханзат, Бугахайрхан, Ханан зэрэг газруудаас олон тооны чулуун зэвсэг түүвэрлэсэн байна [Цогтбаатар, Амартүвшин нар, 2003].

2003 онд шинээр байгуулагдсан Археологийн хүрээлэнгийн судлаач Ч. Амартүвшин нар Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутгаар археологийн хайгуул хийж Ханзат, Хүйтэн хошууны орчим тус бүр нэг, Устын дэнж хэмээх газар хоёр, нийт 4 монгол булш малтаж хүний сүлжмэл гээгний үлдэгдэл, дээл хувцасны тасархайгаар ороосон хонгио хэлбэрт гуулин чимэглэл зэрэг сонирхолтой хэрэглэгдэхүүн илрүүлсэн байна [Цэвээндорж нар, 2003]. Булшны хэрэглэгдэхүүнийг нийтлээгүй.

2003 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Бухын хошуу хэмээх газар нутгийн ардуудын сүйтгэсэн монголын үеийн нэгэн булшнаас гарсан торгон дээл, үйсэн саадаг, харвуулын сумны зэв зэрэг олдворыг Монголын Үндэсний Түүхийн Музейн ажилтнууд газар дээр нь очиж авчран Улаанбаатар дахь музейн сан хөмрөгт шилжүүлжээ. Мөн булшнаас гарсан алтан ээмэг, бүсний чимэглэл зэрэг зүйлүүдийг тус музейн эрдэм шинжилгээний ажилтнуудын идэвх зүтгэлийн үр дүнд ухвар мөчид хүний гарт үрэгдүүлэлгүй музейн фондод шилжүүлэн авсан нь Монголын соёлын өвийг хамгаалахад чухал ажлын нэг болов.

2004 онд Археологийн хүрээлэнгийн судлаачид Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Нарийны аманд нэг хүннү булш малтсан байна [Цогтбаатар, Амартүвшин нар., 2005].

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Бухын хошуунд 2005 онд Монголын Үндэсний Түүхийн Музей (Ж. Баярсайхан), 2006 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс (Ч. Амартүвшин) дахин тус тусдаа археологийн хайгуул зохион явуулж нийт хоёр булш малтсан байдаг. Үүнд, 2006 оны 9 сард малтсан булшнаас банзан авсны таган дээр нь сийрс дэвссэн европ төрхийн хүний хөмөглөсөн оршуулга илэрсэн бөгөөд ясанд нь хийсэн хүн судлалын шинжилгээгээр халдварт өвчнөөр насан эцэслэсэн болохыг урьдчилан тогтоосон ажээ.

2006 онд Монгол-Японы хамтарсан “Зүүн Монголын палеолитын судалгаа” хээрийн шинжилгээний ангийн судалгааны хэсэг (Т.Цурумару, Б.Цогтбаатар, Я.Такаши, Г.Лхүндэв Я.Шино, Ф.Мики) Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаан хадны чулуун зэвсгийн сууринд судалгаа хийсэн байна.

2006 оны хавар Монголын Үндэсний Түүхийн Музейн судлаачид (А.Очир, Л.Эрдэнэболд) Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Хэнтий аймгийн Галшар сумдын зааг нутаг, Их Оорцог ууланд тав, Бага Оорцог ууланд зургаа, нийт 11 булш малтаж гарсан хэрэглэгдэхүүнд үндэслэн XIII-XIV зууны монголчуудын оршуулга гэж үзсэн байна.

Мөн Монгол-Японы хамтарсан “Зүүн Монголын палеолитын судалгаа” хээрийн шинжилгээний ангийн судалгааны хэсэг 2006 оны 09-р сард Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэн Баян-Улаан уулын Ханзат хэмээх газар хөрсөн дээрээ палеолитын дээд үеийн чулуун зэвсгийн баялаг дурсгалыг агуулсан сууринд соёлт давхарга байгаа эсэхийг тогтоох малтлагыг дөрвөн газарт явуулж нэгээс нь харьцангуй нимгэн боловч олон арван чулуун зэвсэг, амьтны ясны үлдэгдэл бүхий давхрага илрүүлэн олдворын нарийвчилсан судалгаа хийж байна [Izuho, Tsogtbaatar et al., 2007 a, b; Hayashi, Izuho et al., 2007]. Монголын чулуун зэвсгийн судалгааны түүхийг товч тоймлон танилцуулахад ийм байна.

2006 оноос Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн хээрийн шинжилгээний анги Дорнод Монголын нутгаас илрэн олдсон хүннүгийн язгууртны томоохон оршуулгын газруудын нэг болох Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг Дуурлиг нарсанд ажиллаж байна. Одоогоор тус төслийн судлаачид

язгууртны хэд хэдэн булш, онгоныг малтан судлаад байгаа [Рэгзэн, Батболд, 2007] нь Дорнод Монголын нутагт хүннүгийн язгууртны бунхант булшийг анх түрүүн малтан судласан явдал билээ.

Мөн 2001 оноос хойш Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Аваргын балгасанд Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийг өнөөг хүртэл хэрэгжүүлж байгаа билээ.

1.2. Монголын археологийн үечлэл

Чулуун зэвсгийн үе

Чулуун зэвсгийн үе нь хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн үе юм. Чулуун зэвсгийн үеийг палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үе, неолит буюу шинэ чулуун зэвсгийн үе хэмээх гурван үед хуваан судалдаг.

Түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид эртний хүмүүс чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил, хүрээлэн буй орчин, амьд байгальтай харьцах харьцаа, байгалийн хатуу ширүүнд дасан зохицох, шинэ газар нутгийг эзэмших зэрэгт томоохон өөрчлөлт дэвшилт гаргасаар иржээ.

Энэ үед хүний эрт үеийн өвөг бүрэлдэн бий болж, орчин үеийн арьстнууд үүсэн, дэлхийн бөмбөрцөгийн өнцөг булан бүрийн байгал цаг уурын таатай нөхцөл бүхий газар нутгийг эзэмших үйл явц явагджээ.

Хуучин чулуун зэвсгийн үе (800.000-12.000 жил). Палеолитын үеийг доод, дунд, дээд гэсэн гурван том үед хуваан авч үздэг.

Доод палеолитын үе (800.000-100.000 жил): Монгол орны палеолитын үеийн хамгийн эртний үед холбогдох олдворууд бүхий бууц суурин Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Баянлиг сумын Цагаан агуй, Жаргалант сумын Байдрагын гол, Шинэжинст сумын Босго, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Ханбогд сумын Оцон Мааньт, Ховд аймгийн Манхан сум Хойт Цэнхэрийн гол, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц зэрэг олон газраас олджээ.

Доод палеолитын үед Монгол нутагт оршин амьдарч байсан хүний хөдөлмөрийн гол зэвсэг нь хугадас, гилбэр ба мэсэн зэвсэг байсан бөгөөд тэдгээр нь цохих, цавчих, хэрчих, хусах зэрэг олон үйлд хэрэглэгдэж байжээ. Тэр үеийн хүн эдгээр үндсэн зэвсгээс гадна бүхэл чулуунаас хэлтэлж авсан хурц ирмэгтэй зузаан нимгэн залтас, ялтас, мөн арслан заан, савгат хирс зэрэг аварга том амьтны яс, модон бороохой, шийдэм зэргийг ашиглаж байжээ.

Дунд палеолитын үе (100.000-40.000 жил) Дунд палеолитын үндсэн зэвсэг нь таргил үлдэцнээс өргөн залтас цуулан авч түүний ир ирмэгийг дахин засаж хийсэн гурвалжин мэс хянгар юм. Хурц ирмэгтэй гурвалжин мэсийг хутганы зориулалтаар, нимгэн мэсийг мод, ясанд суулгаж жад маягаар хэрэглэж байснаас гадна хянгарыг арьс шир янзлах, мод, ясан эдлэл хийхэд голчлон ашиглаж байсан.

Монгол орны нутгаас дунд палеолитын буюу Мустьен үед холбогдох бууц суурингууд олон тоогоор олдсон бөгөөд харьцангуй сайтар судлагдсан нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Орхон I, Орхон VII (9, 10 дугаар давхарга), Богд сумын нутагт орших Арц Богд, Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Аргалант I, Орог нуур I, II, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Оцон мааньт зэргийг дурдаж болно.

Дунд палеолитын үед чулуун зэвсгээс гадна түүнтэй холбогдсон өдөр тутмын үйл ажиллагаанд том амьтдын ясыг бага зэрэг засаж зэвсэг хийх, модон савааны үзүүрийг галд түлж хатууруулан жадны оронд хэрэглэх, том бөөрөнхий чулууг дүүгүүр болгон ашиглах явдал байжээ. Дунд палеолитын үед гал гаргаж хэрэглэж сурсан явдал нь энэ үеийн хүний хөгжилд хамгийн чухал түлхэц болсон.

Дээд палеолитын үе (40.000-12.000 жил) Дунд палеолитоос дээд палеолитод шилжих үед орчин үеийн хүн (*homo sapiens sapiens*) бий болсон нь юуны өмнө чулуун зэвсгийг шинэ арга барилаар хийдэг болсноор илрэх бөгөөд энэ үед гонзгой хэлбэрийн үлдэцнээс нимгэн урт хутган ялтас тал бүрээс нь уртааш нь цуулж түүнийхээ ирмэгийг нэг ба хоёр талаас нь дахин холтчин засаж хурц ир гаргадаг болжээ. Чулууг цуулах ба сэлтлэн ирлэх болсон нь тэр үед чулуун зэвсэг хийх үйл ажиллагаанд гарсан нэг ёсны шинэ оньсон арга байжээ.

Энэ үеийн хүний амьдралын ул мөр болох чулуун зэвсгийн зүйлс манай орны нутгаас түгээмэл байдлаар олддог. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын ам, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт Төлбөрийн голын суурин зэргийг нэрлэж болох юм.

Дундад чулуун зэвсгийн үе (12.000-7.000 жил). Мезолитын үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдаж, эртний хүмүүс нум сумыг зохион бүтээжээ. Энэ үед Умард Ази, Өрнөд ба Дорнод Европод түрж орсон их мөстлөгийн үе нэгэнт дуусч цаг агаар эрс зөөлөрч Умард Ази (Сибирь) их ойт бүс, Төв Азийн байгал газар зүйн байдал, амьтан ургамлын аймаг орчин үеийн төрхийг олсон байна.

Манай орны Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй, Дорнод аймгийн Халх гол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын орчим Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Мойлтын ам (I үе), Хэнтий аймгийн Рашаан хад (II-III үе), Дорноговь аймгийн Дулааны говь, Өмнөговь аймгийн Булган сумын Баруун, Зүүн хайрхан уул болон Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн зарим газраас мезолитын үеийн дурсгалыг илрүүлэн судалжээ.

Шинэ чулуун зэвсгийн үе (8.000-3.000 жил). Неолитын үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан үйлдвэрлэхүй аж ахуй ба өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.

Неолитын үед чулуугаар зэвсэг хийх дадлага туршлага, арга ухаан өмнөх үеэс улам илүү хөгжиж ахуй амьдралын аливаа хэрэгцээнд олон төрөл эдлэлийг маш нарийн хийцтэй үйлдэх болжээ. Ялтасыг шовгор үлдэцний бүх талаас уртааш нь цуулах болсон тул тэр нь зөв талт урт хутган хэлбэртэй болсон байна.

Чулуун эдлэл хийхэд гарсан энэ үеийн нэг гол онцлог нь чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, хөрөөдөж ховил гаргах, өрөмдөж цоолох аргыг сэдэж олсонд оршино.

Неолитын үед Монгол оронд оршин суугчид чулуун зэвсгээс гадна ясаар хийсэн эдлэл өргөн хэрэглэж байжээ.

Неолитын үеийн хүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бас нэг чухал шинэ ололт нь шавар ваар, сав бүтээн хийж хэрэглэх болсон явдал юм.

Дээр дурдсан төрөл бүрийн зэвсэг, ваар сав бүхий тэр үеийн хүний бууц суурин Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий зэрэг тус орны ихэнх нутгаас олджээ.

Хүрэл зэвсгийн үе

МЭӨ II мянган жилийн тэртээгээс Евразийн хээр тал нутагт хүрлээр хийсэн эдлэл өргөн тархаж эхэлжээ. Ойролцоогор МЭӨ II мянган жилийн тэртээ зэсийг цагаан тугалга, хар тугалгатай хольж хайлуулан хүрэл гэдэг шинэ холимог төмөрлөгийг гарган авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүрэл зэвсгийн үе эхэлсэн гэж үздэг. Хүрэл зэвсэгт шилжсэн үе нь эдийн соёлд гарсан хувьсгал байгаад зогсоогүй аж ахуй, нийгмийн харилцаанд ч үндсэн өөрчлөлт гаргасан юм. Хүрэл зэвсгийн үед амьдарч байсан хүмүүс, эртний хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсан дурсгалууд, түүвэр олдвор, дөрвөлжин булш, хиригсүүр, буган хөшөө, хадны зосон зураг, хадны сийлмэл зураг зэрэг олон төрлийн дурсгалыг үлдээсэн байна.

Дөрвөлжин булш. Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Дөрвөлжин булш жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурваараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр нь барьж байгуулсан байдаг. Дөрвөлжин булш дорнод Монголын талаас Алтайн уулс, Байгал нуураас Говь хүртэл өргөн тархсан археологийн томоохон дурсгал юм.

Дөрвөлжин булшны зохион байгуулалтыг авч үзвэл, хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, том зузаан хавтгай чулуунуудаар дарж таглан шороогоор булаад дээр нь хавтгай чулууг босгон эгнүүлэн дөрвөлжлөн зоож, дотор гадна хаяаг нь арай багавтар чулуугаар дарж бэхэлсэн байдаг.

Хиргисүүр. Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Хиргисүүрийг үйлдэгчид нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн

нүүдэлчид байсан гэдэг нь түүний дөрвөлжин булш, буган хөшөөтэй нэг дор нэгэн цогцолбор болон оршин байдгаас илэрхий. Манай орны нутаг дэвсгэр дээр байгаа хиргисүүрүүд нь гаднах хэлбэр төрх зохион байгуулалтын хувьд гуч орчим төрөлд хуваагдана Хиргисүүр нь том хэмжээний дугуй овгор чулуун дараас, түүнийг тойруулан чулуу эгнүүлэн зоож дугуй, дөрвөлжин хүрээ татсан байдаг. Судлаачид хиргисүүрийг МЭӨ II мянган жилийн төгсгөл МЭӨ I мянган жилийн эхэн үед холбогдуулан авч үздэг.

Буган хөшөө. Гонзгой урт чулууг засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг. Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжал хутга, билүү, байлдааны алх, нум, хоромсого, жад, бамбай, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг. Буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судлаж энэ завсар 700 орчим буган чулуун хөшөөг олж илрүүлжээ. Эдгээрээс хамгийн их буюу 550 орчим нь Монгол улсын нутгаас олджээ.

Хадны зураг. Монгол орны нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн үлдээсэн өөр нэгэн хосгүй дурсгал бол хадны зураг юм. Энэ үед холбогдох хадны зургийг улаан зосон, сийлмэл хэмээн ангилан авч үздэг. Монгол орны хүрэл зэвсгийн үед холбогдох улаан зосон зургийн гол төлөөлөгч нь “Сэлэнгэ”-ийн төрлийн зосон зураг юм. Монгол нутагт амьдарч байсан хүрлийн үеийн овог аймгийн гишүүдийн оюун санааны хөгжилтийг харуулах өөр нэгэн томоохон дурсгал бол хадны сийлмэл дурсгал юм. Энэ төрлийн дурсгал монгол нутгийн хад чулуунд харьцангуй олон тоотой байдаг төдийгүй нэгэн хаднаа өөр өөр үеийн дурсгалууд ч давхарлагдан зурагдаж холилдсон байдаг.

Төмөр зэвсгийн түрүү үе. Төмөр зэвсгийн түрүү үе нь хүй нэгдлийн нийгмийн төгсгөлийн шат бөгөөд тэр үед эртний овог аймгууд төмрийн хүдрийг хайлуулах аргыг эзэмшиж, төмрөөр хөдөлмөрийн багаж, байлдааны зэр зэвсэг үйлдвэрлэх болжээ.

Хүн төрөлхтөний урьд өмнө туулж ирсэн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийг бодоход төмөр зэвсгийн үе богино юм. Үнэн хэрэгтээ төмөр одоо хүртэл үйлдвэрлэлийн чухал үндсэн түүхий эд хэвээрээ байна. Гэвч энеолит /зэс чулуу/ ба хүрэл зэвсгийн үед эртний боолын нийгмийн соёл иргэншил үүссэн /Месопотами, Египет, Грек, Энэтхэг зэрэг/ орнуудаас бусад нутагт амьдарч байсан хүй нэгдлийн үеийн овог аймгуудын түүхийг ангилан судлахад “төмөр зэвсгийн түрүү үе” гэдэг нэр томъёо хэрэглэдэг. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл дэлхийн орон бүрт харилцан адилгүй өөр өөр үед тархсан байна.

Чандманий соёл. Монгол оронд төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан хүмүүсийн аж ахуй, соёлын олон талт асуудлыг улируулан тодруулан судлахад Увс аймгийн Улаангом хотын ойролцоох Чандмань уулнаа малтан шинжилсэн өвөрмөц хэлбэрийн булшууд онцгой ач холбогдолтой юм. Эдгээр булш нь

тодорхой нэгэн овог аймгийн дурсгал болох тул Монголын археологийн судалгаанд тусгай соёл болгон авч үздэг. Чандмань уулын булш гадаад хэлбэр төрх, үхэгсдийг оршуулсан зан үйлээрээ том дөрвөлжин чулуун далантай, чулуун далантай авсгүй, жижиг чулуун австай, дүнзэн бунхантай шороон булш гэсэн үндсэн дөрвөн төрөлд хамаарах ажээ.

Эртний улсуудын үе

Хүннү гүрний үе. МЭӨ III зууны үед хүннүчүүд бусад нүүдэлч аймгуудаасаа хүчирхэгжин аймгийн байгууллын хувьд шинэ шатанд орох эхлэлээ тавьжээ. Хүннүгийн аймгийн холбоог шанью нэртэй хаан захирдаг байсан бөгөөд МЭӨ III зууны үе хүртэл аймаг буюу зонхилогчийн зөвлөлөөр сонгодог байсан боловч дараагаар нь үе залгамжлуулах хэлбэрт шилжсэн байна. Хүннүчүүд Модунг хаан болсны дараагаар хөрш зэргэлдээ аймаг улсуудыг цэрэглэн эзлэж газар нутгаа тэлэн өргөсгөх бодлого баримталсан байна.

Хүннү нарын дотоодын зөрчил болон овог аймгуудын хоорондын тэмцлээс шалтгаалан Хүннү гүрэн нь МЭӨ 57-55 оны хооронд умард, өмнөд гэсэн хоёр хэсэг болон хуваагдаж Хуханье шаньюйгаар толгойлуулсан өмнөд хүннүчүүд Хан улсын харьяанд орж, Хуханьейн ах Чжичжи умард Хүннүг захирах болжээ.

МЭӨ III - МЭ II зуун хүртэлх хугацаанд Төв Азийн өргөн уудам нутагт Хүннү нар нүүдэллэн амьдарч, төр улсаа цогцлон байгуулж, мандан бадарч байсны бодит нотолгоо болох археологийн дурсгалууд Монгол орны нутаг дэвсгэрээс олон тоотойгоор олддог.

Хүннүгийн археологийн дурсгалыг дотор нь булш бунхан, хот суурин, хадны зураг гэж ерөнхийлөн ангилан авч үзнэ.

Хүннүгийн булш бунхан. Хүннүгийн үед холбогдох булш бунханыг оршуулгын зан үйл, гаднах хэлбэр төрх, дагалдуулсан эд зүйл зэргээр нь язгууртны болон жирийн иргэдийн гэж хуваан авч үздэг. Энэ хоёр булш нь гаднах төрх байдал, зохион байгуулалтаараа эрс ялгаатай байдаг төдийгүй булшнаас гарч байгаа эд өлгийн зүйлсийн хувьд ч ялгагдана.

Язгууртны булш нь хэмжээний хувьд харьцангуй том, дөрвөлжин чулуун өрлөг далантай, үүдэвчтэй байдаг. Хүннүгийн язгууртны ийм булш манай орны Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигт, Зурамт, Хужиртын ам, Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгор, Архангай аймгийн Хайрхан сумын Хүнүй голын Гол мод, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Борбулаг, Дуурлиг нарс зэрэг газруудад олон тоогоор байна. Мөн Буриадын нутаг Ильмийн ам, Дерестуй зэрэг газруудад ч хүннүгийн язгууртны бүлэг булшууд байдаг.

Хүннүгийн жирийн иргэдийн булшийг Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт, Үүдэнт, Хөвсгөл аймгийн Галт сумын Нүхтийн ам, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгой, Батцэнгэл сумын Худгийн ам, Солби уул, Хөвсгөл аймгийн их-Уул сумын нутаг Сул толгой, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Бурхан толгой, Төв

аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгой, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга уул зэрэг олон газруудад малтан шинжилжээ.

Хүннүгийн жирийн иргэдийн булш нь дугуй чулуун далантай байх ба далангийн доор нүх ухаж дотор нь банзан авс болон мод чулуугаар хийсэн хашлаганд хүнээ толгойгоор нь хойд зүг хандуулан тэнэгэр байдлаар хэвтүүлэн оршуулсан байдаг. Хүннүгийн жирийн иргэдийн булшийг малтан судалсан хэрэглэгдэхүүнээс үзэхэд сонгосон газар зүйн байршилт, булшны гадаад байдал, бүтэц зохион байгуулалт, булшинд үхэгсдийг оршуулах зан үйл, дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл зэрэг бүхий л талаараа дундад зууны төдийгүй өнөөгийн монголчуудын үхэгсдээ оршуулдаг заншилтай ижил төстэй байгаа нь хүннү монголчууд хоёр нэгэн угсаатан болохыг археологийн талаас нь харуулж буй чухал үндсэн баримт гэж үзэж болно.

Хот суурин. Хүннүгийн археологийн судалгааны чухал хэрэглэгдэхүүний нэг бол тэр үеийн хот суурин юм. Хүннү нар нүүдлийн мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ тодорхой хэмжээгээр газар тариалан эрхлэн хот суурин байгуулан сууж байсан байна.

Төв аймгийн Борнуур сумын Бороогийн суурин, Мөнгөнморьт сумын Хүрээн дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Эрдэнэ сумын Өндөр дов, Баянжаргалан сумын нутаг Хэрлэн голын Цагаан арлын Гуа дов, Дорнот аймгийн Цагаан-Овоо сумын Баруун Дөрөөгийн хэрэм, Барс хот II, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын зааг нутагт орших Цэнхэрийн голын хэрэм, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Шувуутайн голын хэрэм, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Баянбулагийн турь зэрэг Хүннүгийн үед холбогдох хот суурины үлдцийг археологийн хайгуул шинжилгээний ажлын явцад олж илрүүлэн заримыг малтан судалжээ.

Хадны зураг. Хүннү нарын үлдээсэн археологийн дурсгалын өөр нэг төрөл бол хадны зураг юм. Манай орны нутаг дэвсгэрээс олдсон хэдэн мянган хадны зургаас судлаачид Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг нутаг Ямаан усны хавцлын Ханан хаданд дүрслэгдсэн гурвалсан морь хөллөсөн сүйх тэрэг, тамган дүрс, Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын нутаг Цагаан салаагийн хаднаа буй нохойд хөөгдсөн аргалийг угтан харваж буй анчныг дүрсэлсэн зургуудыг хүннүгийн үед холбогдуулан авч үздэг. Гэвч Хүннүгийн үед холбогдох зурагнууд нэлээд байх боловч тэдгээрийг одоо хир нарийвчлан судлаагүй байгаа билээ.

Түрэгийн үе. Түрэгүүд нь Төв Азид эрт цагаас оршин нутагласаар ирсэн, түүх соёл, угсаа гарлаараа монголчууд, тэдний өвөг дээдэстэй туйлын ойрын холбоотой нүүдэлчин ард түмэн юм. Монгол болон зөрчид угсаатны нэгэн адил алтай язгуурын хэлний бүлэгт хамаарах түрэгүүд YI-YIII зууны үед нийт Төв Ази түүний дотор одоогийн Монгол нутгийг харьяандаа багтаасан хүчирхэг хаант улсыг байгуулж энэ бүс нутаг дахь түрэг угсаатны 400 орчим жилийн ноёрхлын эх үндсийг тавьжээ.

Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйлийн дотор хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн

бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдыг оршуулсан булш хиргисүүр зэрэг зүйлс орж байна.

Тахил тайлгын онгон. Түрэгийн тухайт эд өлгийн дурсгал, нэн ялангуяа тэдний хамгийн их нийтлэг бөгөөд өргөн тархсан дурсгал болох тахил тайлгын онгоны цогцолборууд нь түрэг угсаатан оршин суусан Евразийн уудам нутгаар өргөн тархсан бөгөөд манай орны Хэнтийн уулсаас Алтайн их уулсыг хүртлэх нутагт элбэг олддог. Эдгээр нь уг нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их бага, янз бүрийн хэмжээтэйгээс гадна бүтэц зохион байгуулалтаараа ч эрс ялгаатай байв.

Жирийн иргэдийн онгон нь хавтан чулууг газарт хайрцаглан суулгаж хийсэн дөрвөлжин хашлага, түүний өмнө (зүүн талд) байрлуулсан хүн дүрст чулуун хөшөө, уг хөшөөний өмнөөс наран ургах зүгийг чиглүүлж цувруулан зоож тавьсан балбал хэмээх зэл чулуун эгнээ зэрэг үндсэн хэсгээс бүрдэнэ.

Язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож өмнө нь нэлээд бодитой уран хийцтэй хүн чулуу тавьж олон тооны зэл чулуу цувуулсан байна.

Хүн чулуу. Түрэгийн тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүн чулуун хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг сэргээн тодруулж судлахад онцгой ач холбогдолтой эх сурвалж баримт төдийгүй тэр үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ төвшинг илтгэн харуулдаг байна. Монгол нутагт эдүгээ нийт 500 гаруй хүн чулуу илрүүлэн олж бүртгээд байгаагийн 400 гаруй нь түрэгийн үед холбогдох ба цаашид ч шинээр нэмэн олдох боломжтой юм. Хүн чулуу хэмээх нь боржин, гантиг, хүрмэн чулуу, элсэн чулуу занар зэрэг чулуугаар хүний дүрс оруулан хийж тахил тайлгын онгоны бүрэлдэхүүнд оруулан босгодог хөшөө юм.

Уйгурын үе. Түрэгийн хаант улс мөхсөний дараа түүний ор суурийг Уйгур улс эзэлж VIII-IX зууны үед Монгол нутагт ноёрхлоо тогтоожээ. Уйгур нь мөн алтайн хэлний бүлэгт багтах түрэг угсаатан байв.

Уйгурчууд хот балгад барьж суурьшин суух талаар бусад нүүдэлчдээс нэлээд онцлогтой байлаа. Тэд манихейн шашныг дэлгэрүүлж согдын гар урчуудын туслалцаатайгаар энэхүү шашны сүм дугана барьдаг байжээ. Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн тогтсон байжээ. Манай улсын нутагт Уйгур улсын сүр жавхлантай нийслэл Ордубалык буюу Хар балгас, шашин номын томхон төв болж байсан Сэлэнгэ мөрний хөвөөн дэх Бийбулагийн балгас зэрэг хотууд байдгийг археологийн талаар бага сага шинжин судалж байжээ. Уйгурууд, Монгол нутагт оршин тогтнож байсан олон аймаг, улсын дотор нэлээд дээгүүр соёлтой байжээ. Тэр үеийн дурсгалын тоонд, "Сэлэнгийн бичээс" хэмээн алдаршсан Могойн шинэ усны гэрэлт хөшөө,

Архангай аймгийн Тариат сумын нутаг дахь Тэрхийн бичээс зэрэг бичиг үсгийн томхон дурсгалууд орно.

Кидан. Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын нэг нь Кидан улс юм. 901 онд Киданы хаанаар Елюй овгийн Амбагян тодрон гарч эрх мэдлээ бэхжүүлэн хуучин найман аймгийг үндэс болгон Кидан улсыг байгуулжээ. Кидан гүрэнд 55 аймаг улс багтсан ба тэдгээрийг өмнөд замын 16 аймаг, умарт замын 28 аймаг, гадаад 8 аймаг гэж хуваадаг. 5 нийслэлтэй, газар нутаг нь дорнод далайгаас Алтайн уулс, Хэрлэн голоос Хятадын цагаан суваг хүртэл өргөжсөн байна.

Монгол нутгаас Киданы үед холбогдох археологийн дурсгалууд бусад үеийнхийг бодвол харьцангуй цөөн тоогоор олддог. Монгол нутагт буй Кидан нарын холбогдолт археологийн дурсгалаас хамгийн олон тоотой хийгээд харьцангуй сайн судлагдсан нь хот балгадын үлдэц юм. Монголд олддог Киданы холбогдолт археологийн дурсгалын дотор хот суурины дурсгал зонхилж байдаг. Түүхийн сурвалж бичиг, археологийн мэдээгээр манай улсын нутагт киданы үеийн арваад хот мэдэгдэж байна. Киданы булш оршуулгын дурсгалыг малтан шинжилсэн байдлаас үзэхэд эл төрлийн дурсгал, тэдний уугуул нутаг Шар мөрөн, Урчи мөрөн зэрэг нутгаас их олддог байна. Киданы булшийг зохион байгуулалтынх нь хувьд нүх ухаж оршуулсан булш, газар дор хонгил хийж оршуулсан хаад ноёдын булш гэсэн үндсэн хоёр хэсэгт хувааж үздэг.

Дундад зууны үе

Монгол гүрний үе. Төв Азид ноёрхон байсан Кидан гүрэн XII зууны үед мөхсөний дараа монгол угсааны овог аймгууд Хятадын цагаан хэрмээс Сэлэнгийн эх хүртлэх нутгийг эзлэн оршиж байв.

XIII зууны эхээр эдгээрийн дотроос Хамаг Монголын ханлиг нэн хүчирхэгжин нийт монгол угсаатныг нэгтгэн 1206 онд Онон мөрний эхэнд их хуралдай хийж Тэмүжинг Чингис хаан цолоор өргөмжлөн Их Монгол улсыг байгуулжээ. Ингээд Чингис хаан засаг захиргаа шинэчлэн тогтоож цэргээ зохион байгуулж, хил хязгаараа өргөтгөн тохинуулжээ. Чингис хааны зарлигаар Хар Хорумд улсын нийслэлийг байгуулж, дараах хаадын үед өргөтгөн барих ажлыг гүйцэтгэсээр иржээ. Харин 1260 онд Хубилай хаан улсын нийслэлийг өмнө зүг шилжүүлж Хятад газар төвлөрөн сууж улсын нэрийг Их Юан болгон өөрчилжээ. 1368 онд Монголчуудын байгуулсан Их Юан улс Хятадын босогчдод цохигдон мөхсөнөөр монголчууд уугуул нутагтаа төвлөрөх болсон ч өмнөх сүр хүч нь доройтон суларч өөр хоорондоо тэмцэн хямарсан бутралын үе эхэлжээ. Энэ байдал удтал үргэлжилсээр 17-18-р зууны үед монголчууд бүхэлдээ Манж Чин гүрний мэдэлд орж улс төрийн тусгаар тогтнолоо алдахад хүргэсэн юм.

Хот суурин. Монголчуудын байгуулсан хот суурингаас хамгийн сайн судлагдсан нь XIII зууны Монголын Эзэнт гүрний нийслэл Хар Хорум хот юм. Хот нь эргэн тойрон хүрээлсэн шавар хэрэмтэй, дөрвөн талдаа хаалгатай, төв

хэсэгтээ огтлолцсон хоёр их гудамжаар гар урлал, худалдаа арилжаа, орд харш, сүм хийдийн гэх хэдэн үндсэн хэсэгт хуваагдаж байв. Хар Хорум хотын барилга байгууламжийн зохион байгуулалт, гоёл чимэглэлийн хэрэглэгдэхүүнээс IX-XII зууны үеэс уламжлан ирсэн орон нутгийн уран барилгын арга барил харагддаг. Тэр үед монгол оронд Хар Хорумаас гадна хэд хэдэн хот байсныг сурвалж бичгийн мэдээ гэрчлэх бөгөөд, тухайлбал, Саорин, Тосху болон хааны дөрвөн их орд гэж байжээ. Одоо мэдэгдэж байгаагаар монголчуудын барьж байгуулсан хот суурины хамгийн эртнийх нь XII зууны үед холбогдох Аврагын балгас юм. Энэ нь Хэрлэн голын баруун гарын цутгал Аваргын голын хойд эрэгт Рашаан дэрсний ухаа хэмээх уулын өмнө бэлд орших ба 4,5 ам дөрвөлжин км талбайтай.

Археологийн судалгааны явцад Монголын их гүрний үед холбогдох өөр бусад хотуудыг ч илрүүлэн олж ямар нэгэн хэмжээгээр малтан судалж байсны тоонд Хэрлэн Барс, Хар хул хааны балгас, Шаазан хот, Халтарын балгас зэргийг дурдаж болно.

Монголчуудын булш оршуулга. Дундад зууны монголчуудын нийгмийн харилцаа, үйлдвэрлэх хүчний хөгжил, зан суртахуун, шашин шүтлэг, ахуй байдлыг бодитойгоор судлан шинжихэд чухал ач холбогдолтой дурсгалын нэг нь тэр үеийн булш оршуулга юм.

Түүхийн сурвалжид тэмдэглэн үлдээснийг үзвээс эртний монголчууд нас барсан хүнээ газрын хөрсөн нүх малтаж булшлан оршуулах ба тэр хүний амьд ахуйдаа хэрэглэж асан эд юмсын зүйлсээс дагдлуулан хийдэг байсныг тодорхой өгүүлжээ. Эртний энэ заншил шарын шашин Монголд дэлгэснээр орхигдож нас барсан хүнээ ил задгай нутаглуулах болжээ.

Эдүгээ манай улс болоод ОХУ-ын нутагт монгол булш малтан шинжилсэн байдлыг үзэхэд эгэл жирийн иргэдийн булш оршуулга голлож байна. Эдгээрийг газар зүйн байрлалыг ажиглахад ямар нэгэн уул, өндөрлөг газрыг сонгон авч уулын өмнөд энгэр, хормой бэл, тэгш дэвсэг газар оршуулдаг нь хаа ч нийтлэг үзэгддэг юм. Дундад зууны монгол булш ихэвчлэн газрын хөрсөн дээр чулуу өрж хийсэн, чулуун дараасны өрлөг нь урт талаараа умар зүг чиглэсэн, цөөвтөр чулуутай, нуугдмал байдалтай байна. Дараасыг хуулж авахад голдуу дан шороогоор булж төдий л гүн биш, австай, авсгүй хоёр янзаар оршуулсан байдаг.

Хүн чулуу. Монгол оронд байгаа хүн чулуу нь VI-IX зууны Түрэг овог аймгуудын, XIII-XIV зууны Монгол гүрний үеийн хүн чулуу хэмээх үндсэн хоёр төрөлд хамаарна. Монгол гүрний үеийн хүн чулуу Монгол улсын зүүн өмнөд хэсгээр байрлажээ. Монголын үеийн хүн чулууг баруун гартаа хундага барьж, зүүн гараа сандлын түшлэгт, эсвэл өвдөг дээрээ тавин түшлэгтэй сандалд суугаа байдлаар урладаг. Мөн энэ үеийн хүн чулууг зөв тийш дарсан ташуу энгэртэй, урт хормой, нарийн ханцуйтай дээлтэй, мухар буюу шөвгөрдүү, заримдаа яльгүй ээтийж эргэсэн хоншоортой гутал өмссөнөөр дүрсэлсэн нь түрэг болоод бусад төрлийн хүн чулуунаас их ялгаатай байна.

Монголчуудын хүн чулуун хөрөг нь тухайн үеийн хүмүүсийн бодит дүр төрх, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, эдлэл хэрэгслэлийн онцлогийг тусган харуулах

түүхэн чухал сурвалж болохын зэрэгцээ тэр үеийн монголчуудын гоо сайхны мэдрэмж, урлаг уран сайхны түвшин, урчууд дархчуудын ур чадварыг илтгэн харуулах дүрслэх урлагийн үнэт дурсгал болох юм.

2. Судалгааны ажлын түүх

2.1. Хээрийн судалгаа хийх болсон хууль, эрхзүйн үндэс

“Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан байдаг. Мөн түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль бий. Энэхүү хуулийн 5 дугаар бүлгийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна”. 27.9-д “Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцана”. 27.10-т “Урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно” хэмээн тус тус заасан байдаг.

Мөн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор БСШУ-ны сайдын 2015 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн А/141 тоот дугаар тушаалын 3 дугаар хавсралт буюу “Соёлын өвийн судалгаа хийх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.2 болон 3.1-т дээрх заалтыг тодорхойлон заасан байна.

Монгол улс нэгдэн орсон соёлын өвтэй холбоотой ЮНЕСКО-ийн конвенциуд. Олон улсын хамтын нийгэмлэг – ЮНЕСКО 1972 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай Конвенци, 2003 онд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийг тус тус батлан гаргасан нь дэлхий нийтэд түгээмэл ач холбогдолтой, хосгүй гайхамшигт байгалийн болон соёлын өвүүд, улс үндэстэн бүрийн амьдралын хэв шинж, өвөрмөц онцлогийг тугасан, түүний нэрийн хуудас, таних тэмдэг болсон соёлын биет бус өвүүдийг хадгалж хамгаалах, өвлүүлэх үйл явцад томоохон алхам болсон юм.

Монгол Улс 1964 онд, “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенци”-д нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч, тууштай дэмжиж ирлээ. Монгол Улс 1990 оноос хойш хүн төрөлхтний нийтлэг замд нэгдэж, дэлхий дахинд нээлттэй болж эхэлсэн нь олон улсын чанартай гэрээ, конвенцид нэгдэн орж ажиллах нөхцлийг бүрдүүлсэн юм. Тухайлбал, 1990 онд ЮНЕСКО-гийн “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци”-д, 1991 онд “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенци”-д, 2005 онд “Биет бус соёлын өвийн конвенци”-д, 2007 онд “Соёлын илэрхийллийн олон төрлийг

хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенци"-д тус тус нэгдэж орсноор тэдгээрийн үзэл санаа, үндсэн зарчмууд болон шаардлагыг соёлын өвийг хамгаалах хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган хэрэгжүүлж эхэлсэн байна. Эдгээр конвенцийн хүрээнд ЮНЕСКО өвүүдийг Дэлхийн өвийн жагсаалт, Соёлын биет бус өвийн Төлөөллийн Дэлхийн жагсаалт, Аюулд учирч буй Дэлхийн Өвийн Жагсаалт болон Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн Дэлхийн жагсаалтанд бүртгэж, хамгаалах арга хэмжээ авч байна. Түүнчлэн 1990-ээд оноос байгаль, соёлын өвөө ирээдүй хойч үедээ өвлөн үлдээх, залуучуудад өв соёлоо дээдлэн хүндэтгэх хүмүүжил олгох, түүнийг хадгалж хамгаалах талаар мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор Дэлхийн Өвийн боловсролын асуудлыг дэвшүүлэн тавьж хэрэгжүүлж байна.

2.2. Хээрийн судалгааг хийх болсон шалтгаан, зорилго ба ажлын төлөвлөгөө

“Эм Си Пи Си Жи Ар” ХХК нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй хатуу хучилттай авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд 115 км (А хувилбар) замын трассын дагуу археологийн авран хамгаалах хайгуул судалгаа /археологийн дурсгалыг бүртгэж баримтжуулах/ хийлгэх хүсэлт ШУА-ийн Археологийн хүрээлэнд тавьсны дагуу 2021 оны 10 дугаар сарын 27-ноос 30-ны өдрүүдэд хайгуул судалгааг хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааны хэсэгт Археологийн хүрээлэнгийн Сан хөмрөг, лабораторийн салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Б.Цогтбаатар, Чулуун зэвсгийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Г.Лхүндэв, Сан хөмрөг, лабораторийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан магистр Э.Амарболд, жолооч Б.Валя нар оролцон ажиллав.

Хавсралт-1: Хайгуулын
ажлын төлөвлөгөө

№	Хугацаа	
1	10 дугаар сарын 25-ны өдөр	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах
2	10 дугаар сарын 27-30-ны өдөр	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй 115 км хатуу хучилттай авто замын трассын дагуу археологийн хайгуул судалгаа хийх
3	11 дүгээр сарын 15-ны дотор	Хээрийн судалгааны үр дүнг боловсруулах, тайлан бичих, хүлээлгэн өгөх

3. Хайгуул судалгаа

3.1. Арга зүй, аргачлал

Археологийн хайгуулын арга зүй, аргачлал

Ямарваа нэгэн зүйлийг зохион байгуулалтайгаар эрэн хайж, олж тогтоох үйлдлийг хайгуул гэдэг билээ. “Хайгуул” гэдэг нь ихэвчлэн шинжлэх ухааны үг хэллэгэнд өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь геологи, палеонтологи, биологи, археологи зэрэг шинжлэх ухааны салбарт түгээмэл ойлголт билээ. Хайгуул нь археологийн судалгааны хамгийн эхний шатны бөгөөд хариуцлагатай ажил юм.

Ангилал

Археологийн хайгуул судалгаа нь эртний түүх соёлын дурсгалыг эрэн хайж, илрүүлэн олох, тодорхойлон, судлан, шинжлэх зорилготой өөрийн гэсэн арга зүйд тулгуурласан судалгааны ажлын нэгэн хэлбэр юм. Археологийн хайгуул судалгааны ажлыг дотор нь нэгдүгээрт, нарийвчлалтай хайгуул, хоёрдугаарт, энгийн, гуравдугаарт хялбаршуулсан гэж гурав хуваан авч үзэж болно.

Нарийвчлалтай хайгуул гэдэг нь хөндий, тэгш тал газар хайгуул судалгаа хийх арга зүй юм. Энэхүү арга зүйг уртраг, өргөргийн дагуу шугаман хайгуулыг гүйцэтгэхэд ашиглах бөгөөд овор хэмжээтэй дурсгалыг хайж олохоос гадна газрын хөрсөн дээр буй хүний нүдэнд тэр бүр ажиглагдахгүй чулуун зэвсэг, шавар савны хагархай, зарим жижиг эд өлгийн зүйлсийг илрүүлэн олоход чиглэгдэнэ [Lightfoot, Kent. 1986].

Ямарваа нэгэн зүйл олсон тохиолдолд түүний байршлын солбилцолыг тогтоох, тухайн олсон зүйлийн талаар тодорхойлолт бичих, олдворыг баримтжуулах зэрэг ажлыг гүйцэтгэж дараагийн шатанд өргөтгөсөн малтлага хийх эсэх талаар зөвлөлдөнө.

Энэхүү хайгуулын арга зүйг уул уурхайн компанийн ашиглалтын талбай болон хайгуулын талбайд хэрэглэх хэрэгтэй юм. Учир нь ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын талбай нь хэмжээний хувьд том, жижиг янз бүр байх боловч тодорхой хүрээнд хязгаарлагдсан байдгаас гадна цаашид энэ газар нь эвдэгдэх, бүрэн устах магадлалтай учир илүү нарийвчлалтай хийх нь зүйтэй.

Энгийн хайгуул. Энэхүү хайгуулын арга зүйг тачир өвстэй уулын бэл, голын дагуух довцог, хуурай сайранд хайгуул хийхэд ашиглахад тохиромжтой. Хайгуулын энэхүү арга зүй нь ямар нэгэн бүс нутагт хайгуул болон дурсгалын талаар тодорхой хэмжээний туршлага мэдээлэл хуримтлуулсны үндсэн дээр хайгуулыг илүү хурдан, олон хүнийг хамарсан байдалтай хийхэд чиглэгдэнэ. Мөн газрын зургийн хүрэлцээ муу буюу тухайн бүсийн нарийвчлалтай газрын зураг байхгүй тохиолдолд агаарын зургийг ашиглан хайгуулыг хийхэд хэрэглэнэ. Учир нь агаарын зураг тодорхой өндрөөс авсан гэх боловч зарим тохиолдолд зургийн алдаа, чанар зэргээс хамаарч газар орчин сайн харагдахгүй, шугамын талаар нарийн мэдээлэл байхгүй зэрэг дутагдалтай байдаг.

Хайгуулын ажлын хамгийн эхэнд агаарын зургийн тусламжтайгаар сонгосон талбайн дөрвөн захын цэгийг GPS багажаар тодорхойлно. Дараа нь хүн тус бүрийн хоорондын зайг хэлэлцэн тогтоно. Талбайн аль нэгэн захаас тогтсон зайгаар явж нөгөө зах хүрэх зэргээр нааш цааш уртраг, өргөргийн дагуу хайгуулыг хийж гүйцэтгэнэ. Ингэснээр нэг шугаманд эгнэн хайгуул гүйцэтгэж байсан хайгуулын хэсэг нь хэд хэдэн хэсэг болон задарч хайгуулын талбайд өөрсдийн сонголтоор хийж гүйцэтгэх боломжтой болно. Хайгуулын хэсэг болгон өөрсдийн хайгуулын мэдээллийн дэвтэр, дурсгалын ерөнхий дэвсгэр зураг үйлдэх дэвтэр, фото аппарат, GPS зэрэг багаж хэрэгслийг хэрэглэнэ.

Хялбаршуулсан хайгуул. Энэ хайгуулын арга зүйг сонгож авсан хайгуул хийх талбай болон түүнээс гадагш харьцангуй хол талбайд хайгуул хийхэд хэрэглэнэ. Гол болон уулсын хоорондох битүү мод бүхий хайгуулын талбайд тухайн хайгуулын хэсэг ямар нэгэн зайд баригдахгүй, хүн явах боломжтой газраар явж шалгаж үзнэ. Ийм уулын бүсэд археологийн дурсгал ховор байдаг боловч хайгуулын гол зорилго бол сонгосон талбайдаа ямар нэгэн газрыг үлдээлгүй, олон янзын арга зүйгээр хайгуулд хамруулах явдал билээ. Мөн өөр нэгэн зүйл бол сонгосон хайгуулын талбайгаас гадагш ойролцоо зарим газрыг үзэж танилцах, өөрсдийн талбайтай харьцуулах зайлшгүй шаардлага урган гарна. Талбай илүү том, зам урт учир үүнийг автомашинаар хийж гүйцэтгэж болдог. Автомашин явах боломжтой ам, хөндийгөөр орж дурсгалтай танилцах, тэдгээрийн баримтжуулалтыг хийнэ.

Хайгуулд хэрэглэгдэх багаж, хэрэгсэл. Археологийн хайгуулыг хийж гүйцэтгэхэд олон тооны багаж, компьютерийн хэрэгсэлийг өргөн ашигладаг билээ. Үүнд, газрын байршилыг тодорхойлох GPS багаж, GPS багажаар хэмжсэн хэмжилтийг компьютерт оруулан газрын зурагт тэмдэглэх GIS буюу Archview програмууд багтана.

3.2. Дурсгалын баримтжуулалт

Дурсгалын баримтжуулалт нь мэдээллийн сан бүрдүүлэх, цаашдын судалгааг тодорхойлох, дүн шинжилгээ өгөх, хадгалах, хамгаалах талаарх зөвлөмж гаргахад хамгийн чухал шаардлагатай ажил юм.

Хайгуулын явцад ямар нэгэн дурсгал илрүүлэн олсон тохиолдолд доорхи баримтжуулалтыг гүйцэтгэсэн болно. Үүнд,

1. Шугаман хайгуул гүйцэтгэж буй хайгуулын багийн гишүүн дурсгал олсон тохиолдолд бусад оролцогчдыг дуудан хамтран тухайн дурсгалыг бүртгэх ажлыг гүйцэтгэнэ.
2. Дурсгалын дугаарлалт
 - Дурсгалыг дугаарлахдаа хайгуул гүйцэтгэж байгаа талбай болон газрын нэрийг бүтнээр нь буюу товчилсон үгээр илэрхийлээд (Жишээлбэл, Оюу толгой-01, ОТ-01 гэх мэт) ард нь нэгээс эхлэн дугаарлана. Гэхдээ энэ нэр нь цаашид

мэдээллийн санд өгөгдөл болон орох тул өмнөх хайгуулын нэр болон цаашид хийх хайгуулын нэрийг бодолцох нь зүйтэй.

3. Тодорхойлолт бичих

- Тодорхойлолтыг тусгайлан бэлдсэн дэвтэрт дэс дугаарын дагуу бичнэ. Дэвтрийн эхний нүүрэнд тухайн тодорхойлолт бичих хүнд зориулан чухам ямар мэдээлэл оруулахыг сануулсан товч асуултууд бэлдэнэ.
- Газрын ерөнхий байдлыг тодорхойлно.
- Дурсгалтай ойрхон байгаа уул, гол, нуур зэрэг газруудын нэрийг тодорхойлно.
- Дурсгалын гадаад байдлыг тодорхойлох
- Дурсгалын эвдрэл гэмтэл
- Дурсгалын хэмжээг авна. Үүнд анхаарах нэг зүйл байдаг. Энэ бол ямар ч дурсгалыг хойноос урагш, зүүнээс баруун тийш буюу уртраг, өргөрөгийн дагуу хэмжинэ. Нэгдсэн нэг аргачлалтай хэмжилт нь хайгуулын мэдээнд тулгуурласан харьцуулсан судалгаа хийхэд тус болдог.
- Солбицолыг тодорхойлох. Энэ нь мэдээллийн сангийн нэгэн чухал хэсэг бөгөөд солбицолыг UTM эсвэл Lat/Lon hddd.ddddd° форматаар сануулж WGS84 гэсэн солбицолын тохиргоог анхаарах нь зүйтэй.

4. Гэрэл зураг авах. Энэ ажил нь дурсгалын талаарх мэдээллийг бүхэлд хамруулан гэрэл зурагт буулгаад цаашид мэдээллийн сангийн чухал нэгэн эх сурвалж болно.

- Дурсгалын дугаар, хайгуулын талбайн дугаар, он сар өдрийг бичсэн самбарыг бэлдэнэ.
 - Самбарыг дурсгалын гадаад зохион байгуулалтыг халхлахгүйгээр тохиромжтой газар тавиад гэрэл зураг авна. Самбар дээр бичсэн зүйлс нь дурсгалыг мэдээллийн санд оруулахад чухал зүйл учир харагдахуйц бичих хэрэгтэй.
 - Самбарын урд талд хойд зүгийг заасан тэмдэглэгээ тавих. Энэ нь хожим тухайн дурсгалын гадаад зохион байгуулалт, хэлбэрийн ангилал, газар нутгийн тодорхойлолт хийхэд тус болдог.
 - Хэмжээс тавих. Хэмжээсийг харагдахуйц газар уртраг, өргөргийн дагуу хандуулан тавина. Том дурсгалд 100-200 см, жижиг дурсгалд 20-50 см хэмжээтэй хэмжээсийг тавибал илүү тохиромжтой. Энэ нь тухайн дурсгалын талаар хожим хэмжээний талаар мэдээлэл авахад хэрэг болох болно.
 - Гэрэл зураг авахдаа дурсгалыг гол цэгээ болгох нь дамжиггүй боловч цаад талд харагдаж байгаа уул, гол, жалга зэрэг зүйлсийг ямар нэгэн хэмжээгээр оруулан авах хэрэгтэй.
5. Олдвор түүвэрлэх. Энэ нь чулуун зэвсэг, ваарны хагархай, төмөр зэсийн баас гэх мэт жижиг хэмжээтэй олдворыг түүвэрлэх ажил юм.
- Тухайн газарт хамгийн эхэнд хийх ажил бол олдворын тархалтыг тодорхойлох юм. Үүнийг гүйцэтгэхдээ олдворын дэргэд тод өнгийн зориулалтын туг, дарцагийг хатгана. Ингэснээр тархалтыг нүдээр харах боломжтой болох юм.
 - Уртраг, өргөргийн дагуу тархалтыг хэмжин тодорхойлолтонд тусгана.

- Тархалтыг тодорхойлсны дараа хамгийн нягтрал ихтэй газрыг сонгон 1 м.кв талбайд хичнээн олдвор ноогдож байгааг тэмдэглэнэ.
- Олдвор бүхий дурсгалт газраас дээж болгон заримыг түүвэрлэн авч болох боломжтой боловч цаашид сорилтын малтлага болон дараа дараагийн судалгаанд зориулан тухайн газарт нь олдворуудыг үлдээх нь зүйтэй.

Хэрэв олдвор түүвэрлэх зайлшгүй шаардлагатай бол зориулалтын уутанд хамт дурсгалын дугаар, хайгуулын талбайн дугаар, солбицол зэрэг мэдээллийг бичиж хийнэ.

6. Дэвсгэр зураг үйлдэх. Энэ баримтжуулалтын ажил нь гэрэл зураг дээр гарах боломжгүй илүү мэдээллээр хангах зорилготой хийдэг.
 - Дэвсгэр зургийг тойм байдлаар зурна. Учир нь тухайн дурсгал нь хөрсөнд булагдаж анхны төрхийг тодруулах боломжгүй, хайгуул нь цааш үргэлжлэх хугацааг хэмнэхээр тооцоолж буй хэрэг юм.
 - Хайгуулын багийнханд тодорхойлолт бичих дэвтэр, дэвсгэр зураг зурах гэсэн хоёр дэвтэр байна.
 - Дэвсгэр зургийг үйлдэхдээ масштабыг дэвтэртээ тааруулахаас гадна, хожим ойлгомтой байх зорилтыг анхаарах хэрэгтэй.
 - Дурсгалын хойд урд тэнхлэгийн дагуу метр тавьж зурна. Том хэмжээтэй дурсгал дээр тойм төдий зургийг зурж болно.
 - Тэнхлэгийн дагуу масштабээр жижгүүлэн дурсгалын ерөнхий хэлбэрийг зөв гаргана.
 - Мөн зарим тохиолдолд олон дурсгалтай газарт уул, жалга, гол зэрэг онцгой газруудыг тэмдэглэн нүдэн баримжаагаар дурсгалуудын байршлыг зурж болно.
7. Хөрсний шалгалт. Энэ арга зүйг өндөр өвсөөр хучигдсан газарт ашиглана. Тухайн газарт олдвор хүний нүдэнд тодорхой сайн харагдахгүй, хөрсөн доор байх магадлалтай хэмээн үзэж хайгуулд оролцогчид тодорхой зайд, тодорхой хэмжээний газрыг сонгон хүрэээр малтах ажил юм.
 - Хайгуул оролцогчид уртраг, өргөргийн дагуу самнах шугаман хайгуулыг хийхдээ хүрз болон шигшүүртэй гүйцэтгэнэ.
 - Хайгуулд дунджаар 6 хүн оролцож байгаа тохиолдолд 3 хүн хүрз, 3 хүн шигшүүртэй солбин явах бөгөөд шигшүүртэй оролцогч зүүн талд, хүрзтэй оролцогч баруун талд нь гэх мэтээр зохион байгуулж болно.
 - Шугаман хайгуулын 100 м тутамд (үүнийг хайгуулыг ахлаж байгаа оролцогч GPS багажны зай хэмжүүрийн тусламжтайгаар тодорхойлж, бусад оролцогчдод хөрсний шалгалт хийхийг сануулна) нийт хайгуулд оролцогчид зэрэг буюу хүрз авч яваа хүн дунджаар 50x50 см хэмжээтэй, 20-30 см гүнтэй нүхийг малтана. Үүнд зүүн талд яваа шигшүүртэй оролцогч ирж хөрсийг бүрэн шигшиж, ямар нэгэн олдвор байгаа эсэхийг шалгана. Хэрэв шигшүүрээс 5 болон түүнээс дээш олдвор гарсан тохиолдолд дурсгал хэмээн үзэж баримтжуулалт хийнэ. Харин 5-аас доош олдвор гарсан тохиолдолд хайгуулын мэдээнд оруулаад хайгуул цааш үргэлжилнэ.

ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд
Дурсгалын дугаар	01		Хайгуулын талбайн нэр		
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай		Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар		

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Монгол булш
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Дундад зууны үе
Солбицол	N48 32 58.6 E110 33 44.6		Хадгалалт	Маш сайн
ДТД өндөр	1076 м			Сайн
Хэмжээ	Голч			Дунд
	Уртрагийн дагуу	400см		Муу
	Өргөргийн дагуу	500см		
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	06-07

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр	Чиглэл	
	Тоногдсон		хүртлэх зай	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	√
	Уулын бэлд			Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр	√	Хөрс	Хар	√
	Тэгш талд			Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Буглуур чулуу		

Бусад тэмдэглэл

Голын хойд дэнж дээр, машин замын баруун талд 20 м зайд байрлана. Дугуй хүрээтэй төв хэсэгтээ дараасгүй. Хүрээний хэмжээ 400 x 500 см.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд	
Дурсгалын дугаар	02			Хайгуулын талбайн нэр		
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай			Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар		

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Чулуун байгууламж	
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Он цаг тодорхойгүй	
Солбицол	N48 30 22.4 E110 24 41.0		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1097 м			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	200см		Муу	
	Өргөргийн дагуу	150см			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	08-09	

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр	Чиглэл	
	Тоногдсон		хуртлэх зай	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд			Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр	√	Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Буглуур чулуу		

Бусад тэмдэглэл

Намхавтар жалганы баруун талын тэгш дэнж дээр оршино. Гадаад хэлбэр нь ихэд алдагджээ. Таруу байрлалтай цөөн хэдэн чулуу л үлджээ. Хүрээний хэмжээ 200 x 150 см.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд
Дурсгалын дугаар	03			Хайгуулын талбайн нэр	
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай			Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Тахилын хашлага	
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Эртний Түрэгийн үе	
Солбицол	N48 28 59.2	E110 23 06.6	Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1069 м			Сайн	√
Хэмжээ	Голч			Дунд	
	Уртрагийн дагуу	350см		Муу	
	Өргөргийн дагуу	350см			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	10-11	

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр	Чиглэл	
	Тоногдсон		хуртлэх зай	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	√
	Уулын бэлд	√		Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр	√	Хөрс	Хар	√
	Тэгш талд			Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Буглуур чулуу		
Бусад тэмдэглэл					
Уулын бэлд, нуурын хойд талын тэгш газарт оршино. Хавтгай чулууг босгож дөрвөлжлөн үйлдсэн намхан хашлагатай. Төв хэсэгтээ намхан таруу дараастай. Хүрээний хэмжээ 350 x 350 см.					



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд
Дурсгалын дугаар		04		Хайгуулын талбайн нэр	
Хайгуулын талбайн хэмжээ		115 км	авто замын трассын дагуух талбай	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Тахилын хашлага	
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Эртний Түрэгийн үе	
Солбицол	N48 29 24.9	E110 23 40.5	Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1070 м			Сайн	√
Хэмжээ	Голч			Дунд	
	Уртрагийн дагуу	400см		Муу	
	Өргөргийн дагуу	350см			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	12-13	

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоногдсон		Ургамал	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд			Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	√
	Уулын бэлд	√		Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	√
	Тэгш талд	√		Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Буглуур чулуу		

Бусад тэмдэглэл
Тэгш газарт хойноос урагш цуварсан 4-н тахилын хашлага байна. Хойноос нь эхлэн дугаарлав. Зүүн хойд талын хашлага тодорхой мэдэгдэх бол бусад нь хөрс шороонд дарагджээ. Төв хэсэгтээ намхан гаруу дараастай. Дараасны төвд сондгой ганц том хар чулуутай. Хүрээний хэмжээ 400 х 350 см.



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд
Дурсгалын дугаар	05		Хайгуулын талбайн нэр		
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай		Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар		

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Тахилын хашлага	
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Эртний Түрэгийн үе	
Солбицол	N48 29 24.6	E110 23 40.6	Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1068 м			Сайн	√
Хэмжээ	Голч			Дунд	
	Уртрагийн дагуу	500см		Муу	
	Өргөргийн дагуу	500см			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	14-15	

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр	Чиглэл	
	Тоногдсон		хүртлэх зай	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	√
	Уулын бэлд	√		Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	√
	Тэгш талд	√		Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		

Бусад тэмдэглэл

Хойд талаасаа 2 дахь тахилын хашлага болно. Хойд болон зүүн талын хашлага нь тодорхой мэдэгдэх бол бусад нь хөрс шороонд дарагджээ. Төв хэсэгтээ намхан таруу дараастай. Хүрээний хэмжээ 500 х 500 см.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд	
Дурсгалын дугаар	06			Хайгуулын талбайн нэр		
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай			Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар		

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Тахилын хашлага	
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Эртний Түрэгийн үе	
Солбицол	N48 29 24.3	E110 23 40.7	Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1068 м			Сайн	√
Хэмжээ	Голч			Дунд	
	Уртрагийн дагуу	540см		Муу	
	Өргөргийн дагуу	520см			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	16-17	

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр	Чиглэл	
	Тоногдсон		хуртлэх зай	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	√
	Уулын бэлд	√		Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	√
	Тэгш талд	√		Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		

Бусад тэмдэглэл

Хойд талаасаа 3 дахь тахилын хашлага болно. Хойд болон баруун талын хашлага нь тодорхой мэдэгдэх бол бусад нь хөрс шороонд дарагджээ. Төв хэсэгтээ намхан таруу дараастай. Хүрээний хэмжээ 540 x 520 см.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.27	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд
Дурсгалын дугаар	07			Хайгуулын талбайн нэр	
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай			Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Тахилын хашлага	
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Эртний Түрэгийн үе	
Солбицол	N48 29 24.1	E110 23 40.9	Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1068 м			Сайн	√
Хэмжээ	Голч			Дунд	
	Уртрагийн дагуу	500см		Муу	
	Өргөргийн дагуу	500см			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар	18-25	

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр	Чиглэл	
	Тоногдсон		хуртлэх зай	Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	√
	Уулын бэлд	√		Тачир	
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	√
	Тэгш талд	√		Бор	
	Бусад			Элс	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		

Бусад тэмдэглэл

Хамгийн урд талын буюу 4 дэхь тахилын хашлага болно. Хойд, баруун болон зүүн талын хашлага нь тодорхой мэдэгдэх бол бусад нь хөрс шороонд дарагджээ. Төв хэсэгтээ намхан таруу дараастай. Хүрээний хэмжээ 500 x 500 см.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо	2021.10.28	Цаг		Бүртгэгч	Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Э.Амарболд
Дурсгалын дугаар	08		Хайгуулын талбайн нэр		
Хайгуулын талбайн хэмжээ	115 км авто замын трассын дагуух талбай		Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар		

Аймаг	Хэнтий		Дурсгалын төрөл	Булш
Сум	Өмнөдэлгэр, Биндэр		Он цаг	Хүрэл зэвсгийн үе
Чулуун зэвсэг		Чулуужсан яс	
Ваарны хагархай		Төмрийн баас	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл	
Төмөр эдлэл		Бутлуур чулуу	

Бусад тэмдэглэл

Хурх багийн төвийн орчмоос эхлэн Биндэр уулын урд энгэр бэл болон Рашаан хад, Үзүүр цохио, Өглөгчийн гол орчмын газрын хөрсөн дээрээс чулуун зэвсгийн олдворууд олноор олддог. Рашаан хад, Өглөгчийн гол, Үзүүр цохио орчимд чулуун зэвсгийн малтлага судалгаа явуулж дээд палеолит, мезолит, неолитын үед хамаарах чулуун зэвсгийн дурсгалт газар болохыг тогтоосон.

Гэрэл зураг




3.3. Хайгуулаар илрүүлсэн дурсгалын товч мэдээлэл


№	Дурсгалын дугаар	Солбицол		Хэмжээ (см)	Дурсгалын төрөл
		N	E		
1	Дурсгал-01	48 32 58.6	110 33 44.6	400x500 см	Монгол булш
2	Дурсгал-02	48 30 22.4	110 24 41.0	200x150 см	Чулуун байгууламж
3	Дурсгал-03	48 28 59.2	110 23 06.6	350x350 см	Тахилын хашлага
4	Дурсгал-04	48 29 24.9	110 23 40.5	400x350 см	Тахилын хашлага
5	Дурсгал-05	48 29 24.6	110 23 40.6	500x500 см	Тахилын хашлага
6	Дурсгал-06	48 29 24.3	110 23 40.7	540x520 см	Тахилын хашлага
7	Дурсгал-07	48 29 24.1	110 23 40.9	500x500 см	Тахилын хашлага
8	Дурсгал-08	48 27 43.6	110 20 05.8	600x500 см	Булш
9	Дурсгал-09	48 27 43.8	110 20 06.2	300x250 см	Булш
10	Дурсгал-10	48 27 43.5	110 20 06.1	400x300 см	Булш
11	Дурсгал-11	48 24 55.5	110 17 38.6	Голч-1500 см Хүрээ-1800 см	Хиргисүүр
12	Дурсгал-12	48 24 54.9	110 17 37.4	400x500 см	Дөрвөлжин булш
13	Дурсгал-13	48 24 54.7	110 17 37.4	450x500 см	Дөрвөлжин булш
14	Дурсгал-14	48 22 44.9	110 18 09.6	600x500 см	Чулуун байгууламж
15	Дурсгал-15	48 22 44.7	110 18 09.0	200x300 см	Дөрвөлжин булш
16	Дурсгал-16	48 22 44.6	110 18 08.6	200x250 см	Дөрвөлжин булш
17	Дурсгал-17	48 22 45.0	110 18 08.8	Голч-800 см Хүрээ-1000 см	Хиргисүүр
18	Дурсгал-18	48 22 45.3	110 18 09.3	250x150 см	Дөрвөлжин булш
19	Дурсгал-19	48 22 45.5	110 18 09.1	200x150 см	Дөрвөлжин булш
20	Дурсгал-20	48 22 45.5	110 18 09.0	200x300 см	Дөрвөлжин булш
21	Дурсгал-21	48 22 45.5	110 18 08.2	300x250 см	Дөрвөлжин булш
22	Дурсгал-22	48 22 45.2	110 18 08.6	250x200 см	Дөрвөлжин булш
23	Дурсгал-23	48 22 45.2	110 18 08.4	200x200 см	Дөрвөлжин булш
24	Дурсгал-24	48 22 45.0	110 18 08.2	400x300 см	Дөрвөлжин булш
25	Дурсгал-25	48 22 44.8	110 18 07.7	Голч-500 см Хүрээ-700x600см	Хиргисүүр
26	Дурсгал-26	48 22 28.2	110 17 30.7	200x250 см	Дөрвөлжин булш
27	Дурсгал-27	48 22 28.1	110 17 30.4	300x350 см	Дөрвөлжин булш
28	Дурсгал-28	48 22 28.0	110 17 28.9	I: 82x39x20 см II: 70x38x17 см III: 55x39x15 см	Хөшөө чулуу
29	Дурсгал-29	48 22 13.9	110 16 39.1	Голч-1000 см Хүрээ-2000 см	Хиргисүүр
30	Дурсгал-30	48 22 05.4	110 16 02.9	Голч-1000 см Хүрээ-2800 см	Хиргисүүр

31	Дурсгал-31	48 22 03.1	110 15 45.6	500x600 см	Дөрвөлжин булш
32	Дурсгал-32	48 22 03.0	110 15 45.8	26x140 см	Хээтэй хашлага
33	Дурсгал-33	48 09 33.8	110 00 48.4	320x400 см	Булш
34	Дурсгал-34	48 09 34.6	110 00 47.9	Голч-700 см Хүрээ-2100 см	Хиргисүүр
35	Дурсгал-35	48 09 35.0	110 00 47.7	120x200 см	Чулуун байгууламж
36	Дурсгал-36	48 09 34.9	110 00 47.3	300x220 см	Булш
37	Дурсгал-37	48 09 34.7	110 00 47.1	300x250 см	Булш
38	Дурсгал-38	48 07 11.7	109 54 04.8	Голч-600 см	Туурь
39	Дурсгал-39	48 07 02.7	109 53 56.2	Голч-600 см	Шороон байгууламж
40	Дурсгал-40	48 07 01.5	109 53 55.3	Голч-600 см	Туурь
41	Дурсгал-41	48 22 44.1	110 17 56.7		Чулуун зэвсэг


3.4. Дурсгалын тархалтын бүдүүвч зураг



Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй 115 км (А хувилбар) хагуу хучилттай авто замын трассын дагуу байх археологийн дурсгалуудын бүдүүвч зураг



**Замын трассын дагуу илэрсэн дурсгалуудын байрлал зүйн бүдүүвч зураг
(Биндэр уулын зүүн урд хошууны орчимд байх булшны бөөгнөрөл)**



**Замын трассын дагуу илэрсэн дурсгалуудын байрлал зүйн бүдүүвч зураг
Хэнтий аймаг Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр сумдын нутаг**

4. Хэнтий аймгийн нутаг дахь түүхэн дурсгалт газруудын товч танилцуулга

Хууль эрх зүйн үндэслэл:

Чингис хааны өлгий нутгийн түүхэн аялал жуулчлалын нэг чиглэлийн маршрут болох Өмнөдэлгэр – Биндэр чиглэлийн авто зам нь Монгол улсын Засгийн Газрын 324 дүгээр тогтоолоор баталсан “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Монгол улсын Засгийн Газрын 2017 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөрийн 3.8.2-т “Мянганы суут хүн Их Эзэн Чингис хаан” түүхэн аялал жуулчлалын үндэсний парк байгуулах (Хэнтий аймаг) зорилт, Аялал жуулчлалын гол чиглэлийг баталсан Багануур-Хөх нуур-Хангал нуур-Бэрээвэн хийд-Рашаан хад (SR 10, MR 510), Жаргалтхаан-Өмнөдэлгэр-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр-Баян адарга-Дадал (SR 10, MR 520) ерөнхий маршрутын зарим хэсэгт төлөвлөгдөж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Биндэр уулын дурсгалт газар

Хэнтий аймгийн Батширээт сумын Хурх багийн нутагт орших Биндэр уул нь Хан Хэнтий нурууны зүүн урд хэсэг, Сибирийн тайга, Төв-Азийн тал хээрийн шилжилтийн бүсэд хамаарах бөгөөд байгалийн болон түүх, соёлын хосгүй дурсгалт газар юм.


Биндэр уулын эргэн тойрны гол горхиуд Хурхын голоор дамжин Онон голд цутгах бөгөөд энэхүү хөндийг “Монголын нууц товчоон”-д бичигдсэн Хамаг Монголын язгууртнуудын үндсэн нутаг болох “Хорхонаг жубур” мөн хэмээн судлаачид үздэг. Тухайлбал “Хорхонаг жубур”, “Хулдгар хун”, “Химурга горхи”, “Бэдэр хошуу”, “Хорчухуй болдог”-ийг тойрсон олон чухал үйл явдал энэ орчимд болж өнгөрсөн нь “Монголын нууц товчоон”-ы түүхэн газар нутгийн нэр, байршлын судалгаагаар тогтоогдсон.

Үүний зэрэгцээ Биндэр уул түүний ойр орчимд Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгал, Хажуу нуурын буган хөшөө, Өглөгчийн хэрэм, Баянголын амны хүн чулуун хөшөө зэрэг чулуун зэвсгийн үеэс эхлэн хүрэл, түүрүү төмрийн үе, эртний улсуудын үе болон Их Монгол улсын түүхэнд холбогдох олон арван дурсгал хадгалагдаж байна.

Биндэр уул, Рашаан хад орчмын дурсгалын археологийн судалгааг 1943 оноос нэрт эрдэмтэн “Хөдөөгийн” хэмээх Дамдины Пэрлээ (1911-1982) эхлүүлснээр хожмын олон талт судалгааны суурь болж, улмаар 40.000 гаруй жилийн тэртээгээс хүн тасралтгүй суурьшин амьдарч өв соёлоо үлдээсэн, эрт, дундад үеийн овог аймгуудын онгон шүтээний төв нутаг болохыг бататган тогтоосон байна.

“Биндэръяа хан уул”-ын байгалийн дурсгалт газар ангиллаар Монгол Улсын Их Хурлын 2012 оны 57-р тогтоолоор улсын хамгаалалтад авсан.

Хадгалж хамгаалах, судлах, сурталчлан таниулах нэн шаардлагатай хүн төрөлхтний түүх соёлын үнэ цэнэтэй дурсгалт газрын нэг хэмээн үзэж ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад “Тахилгат Биндэр уул түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар” нэрээр 2014 онд албан ёсоор бүртгэгдсэн.



Биндэр уулын орчны өндөршлийн зураг

Хурх, Хүйтний хөндий ба “Тогорууны нийслэл”

Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын зааг нутгийг дамнан орших Хурх, Хүйтний голын хөндий нь дэлхийн хэмжээний ховор болон нэн ховор шувууд нүүдэллэн ирдэг, өндөглөж зусдаг, дамжин өнгөрдөг таатай орчин бүрдсэн тул олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчныг хамгаалах тухай “Рамсарын конвенц”-ийн жагсаалтад 2004 онд бүртгэгдсэн.



Хос тогоруу

Монгол оронд 7 зүйл тогоруу нүүдэллэн ирж зусдаг болон дайран өнгөрдөг бөгөөд ихэнх нь дэлхийд ховор, нэн ховор зүйлд багтана. Дээрх 5-6 төрөл зүйлийн тогорууг нэг дор үзэх боломжтой маш цөөхөн газруудын нэг нь Биндэр уулын орчны бүс болох Хурхын голын хөндий бөгөөд судлаачид болон байгаль хамгааллын мэргэжилтнүүд Монголын “Тогорууны нийслэл” хэмээн нэрлэх болсон онцлогтой. Тиймээс гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын ажиглалт, туршилтын түшиц газар болохын зэрэгцээ тусгай сонирхлын аялал жуулчлалын нэгэн чиглэл болон хөгжих боломжтой юм. Сүүлийн жилүүдэд шувуу судлаачид, төрийн бус байгууллагын санаачлагаар орон нутгийн удирдлага, иргэд хамтран Биндэр суманд жил бүрийн 6-р сард “Тогорууны баяр” сонирхолтой арга хэмжээг зохион байгуулдаг.

Биндэрийн овоо

Биндэр уулыг Чингис хааны өвөг дээдэс Хотула хааны үеэс тахин шүтэж ирсэн домог, түүхтэй. Хуучнаар Сэцэн хан аймгийн Хөвчийн жонон вангийн хошууны гол тахилгат овооны нэг нь Биндэрийн овоо байсан бөгөөд өдгөө Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Хурх, Өмнөдэлгэр сумдын ард иргэд жил бүрийн зуны эхэн сард ээлжлэн тахилгын зан үйлийг хариуцан гүйцэтгэдэг. Халхын Сэцэн хан Шолой (1577-1655), Анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар (1635-1723) нар Ононгийн халуун рашаанд бараалхах замдаа Биндэрийн овоонд саатан тахисан тухай баримт буй.



Биндэрийн овоо

Рашаан хадны цогцолбор дурсгал

Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэр уулын зүүн урд үзүүрт орших Рашаан хад түүний ойр орчимд (1-10км) дээд палеолит, мезолит, неолитийн бууц суурин, палеолитийн үеийн хадны сийлмэл зураг, хүрэл, төмөр зэвсгийн түрүү үеийн хиргисүүр, дөрвөлжин булш, бусад төрөл

хэлбэрийн булшнууд, хадны зосон болон сийлмэл зураг, хэдэн зуун тамга тэмдгийн дурсгал, монгол, төвд, нанхиад, хятан, араб, руни, дөрвөлжин зэрэг 7 төрлийн нийт 60 гаруй бичээс, буган хөшөө, хүн чулуу, эртний бэхлэлт хэрэмний үлдэц зэрэг түүхийн урт удаан он цагт хамаарах олон төрлийн дурсгалууд харьцангуй бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн байна. Анх 1920-оод оны үед нутгийн ард Цэдэнгийн Хайдавданзан гэдэг хүн Рашаан хадны дурсгалт газрын тухай мэдээллийг Судар бичгийн хүрээлэнд ирүүлж байжээ.

Рашаан хад, түүний эргэн тойрон дахь дурсгалыг Монголын ууган археологич Дамдины (Хөдөөгийн) Пэрлээ (1911-1982) анх 1943 оноос судалгааны эргэлтэд оруулснаар хожмын олон судалгааны эхлэл болж, улмаар нэн эртнээс буюу 40.000 гаруй жилийн тэртээгээс хүн суурьшин амьдарч байсан, эрт, дундад үеийн овог аймгуудын онгон шүтээний төв нутаг болохыг судлаачид бататган тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад (2008, 2020 онд шинэчлэгдсэн) орсон.

Рашаан хадтай эн зэрэгцэх археологийн цогцолбор дурсгал одоогоор Монгол улсын нутаг дэвсгэрээс илрээгүй бөгөөд судлах, хадгалж хамгаалах шаардлагатай хүн төрөлхтний түүх соёлын үнэ цэнэтэй өв мөн хэмээн үзэж ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад “Тахилгат Биндэр уул түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар”-ын голлох дурсгалаар 2014 онд албан ёсоор бүртгэгдсэн.



Рашаан хад

Рашаан хадны чулуун зэвсгийн соёлт давхаргатай суурин нь дунд палеолитын эцсээс дээд палеолит, мезолит, неолитын үе хүртэлх үйлдвэрлэлийн хөгжлийг тодорхой харуулдаг.

Тамгат хавтан чулуу

Рашаан хадны цогцолбор дурсгалын гол төв хэсэгт орших дунджаар 6.55 метр урт, 2.95 метр өргөн, 0.7 метр орчим зузаан хэмжээтэй хавтан чулууны газрын хөрсөн дээр ил гарсан гурван талын гадаргуу дээр нийт 300 орчим тамга тэмдэг сийлж үлдээжээ.

Он цагийн уртад ихэнх нь элэгдэж бүдгэрсэн хэдий ч тамга тэмдгийн төрөл зүйлд онгин буюу наран, чойндон буюу гурвалжин тамга, саран тамга, туурай тамга, буйлан тамга, ширээ тамга, дэгрээ тамганууд голлохын зэрэгцээ тэдгээрээс салбарлуулан сийлсэн үүсмэл тамга тэмдгүүд хэдэн арваараа байгаа нь тодорхой харагдана.



Тамгат хавтан чулуу

Монголын ууган археологич, академич Дамдины (Хөдөөгийн) Пэрлээ (1911-1982) уг хавтан чулуун дээрх тамга тэмдгийг харьцуулан шинжилж, “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь” (УБ.,1976) нэгэн сэдэвт бүтээлдээ гол судлагдахуун болгон хэвлүүлжээ.

Олон бичээст хад

Нутгийн ард түмэн Биндэрийн эрүү хэмээн бүхэлд нь нэрлэдэг байсан хадтай хошууны зүүн урагш хандан үе давхарлан тогтсон том хадны завсраас зуны улиралд шүүрч дуслах усыг тосон рашаан хэмээн нүдэндээ дусаах, нүүрээ шавшин угаах зэргээр хэрэглэж ирснээс улбаатай “Рашаан хадны дурсгал” нэрээр эрдэм шинжилгээний ном бүтээлд бичигдэх болжээ. Энэхүү рашаан дусдаг том хад буюу судлаачид, соёлын өвийн мэргэжилтнүүдийн нэрлэснээр “Олон бичээст хад”-ны эргэн тойронд түүхийн урт удаан хугацааны туршид бичигдсэн Руни бичээс 2, Араб бичээс 1, Хятан бичээс 4, Дөрвөлжин бичиг 1, Хятад бичээс 1, Монгол бичээс 29, Төвд бичээс 10 гаруйг илрүүлэн бүртгэсэн байна. Ихэнх нь хар бэхээр бичсэн ба он удаан жилийн цаг агаарын болон бусад

хүчин зүйлийн нөлөөгөөр элэгдэн бүдгэрч бүрэн уншиж судлахад бэрхшээлтэй болсон.

Эрт үеэс олон хэлийн хүмүүс энэ орчмоор дайран өнгөрч бичиг үсгийн дурсгалаа үлдээсэн нь сонирхолтой бөгөөд Монголын төдийгүй бүс нутгийн түүх, соёлын харилцаа холбоог тодруулахад чухал ач холбогдолтой эх сурвалж юм.



Рашаан хадны олон бичээс

Үзүүр цохионы дурсгал

Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Үзүүр цохионы хадтай толгойн оройн хэсгийн зүүн хойд, хойд, өмнө талд эртний овог аймгуудын тамга тэмдэг, адуу мал, хүний дүрс бүхий зургууд таруу байдалтай сийлсэн байдаг. Толгойн зүүн хойд хэсгийн хаданд тав зургаан адууг цувуулан, урд талд нь хоёроос гурван хүн хөтлөн явж байгаагаар нэг шулуунд зурсан бол хүнийг ерөнхийд нь тоймлон сийлж, морьдыг өндөр, урт зэгзгэр биетэй, шулуун хөлтэй хөдөлгөөнгүй зогсож байгаагаар дүрсэлсэн байна. Энэхүү зурагтай хадны баруун талд орших хадны налуу хэсэгт онги, ан амьтны мөр, туурайн дүрст 200 гаруй тамга тэмдгүүдийг сийлжээ.

Судлаачид дээрх хадны зургийг хүрэл зэвсгийн үед хамааруулж үздэг бөгөөд тамга тэмдгүүд нь Рашаан хад орчмын тамга тэмдгүүдтэй хийсэн арга барил, хэлбэр төрхөөрөө ижил төстэй болохыг тэмдэглэсэн байна. Биндэр уулын Рашаан хад, түүний зэргэлдээ Үзүүр цохионд баавгайн сарвууны мөр олон тоогоор дүрсэлсэн нь онцлог бөгөөд дээд палеолитын төгсгөл, шинэ чулуун зэвсгийн үеийн эртний хүний амьдралын орчин, танин мэдэхүй, шүтлэг бишрэлийг илэрхийлэх чухал баримт болно



Үзүүр цохио

Үзүүр цохионы эргэн тойронд газрын хөрсөн дээр палеолит, мезолит, неолитын үеийн эртний хүний хөгжил, үйлдвэрлэлийн ахиц дэвшлийг тодорхой харуулах чулуун зэвсгийн олдвор их хэмжээгээр хадгалагдан үлджээ.

Өглөгчийн хэрэм

Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Дайчин хэмээх уулын орой, энгэрээр тойруулж барьсан чулуун хэрэм. Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад (2008, 2020 онд шинэчлэгдсэн) орсон. Байгалийн чулуугаар үе давхарлан өрж байгуулсан бэхлэлт хэрэмний нэлээд хэсэг нь байгаль, нийгмийн хүчин зүйлийн нөлөөллөөс болж нурсан хэдий ч эдүгээ чулуун ханын дундаж өндөр нь 2.5 метр, хэрмийн зүүн хойд талын нурулт багатай хэсэгтээ 3.5 метр орчим, 2 метр орчим өргөн, нийт 2850 метрийн урт хэмжээтэй хадгалагдаж байна. Гадна талдаа эгц өндөр чулуун өрлөгтэй, дотроосоо бага зэрэг налуу шороон дараастай. Өмнөд талдаа хаалга, дотроо баруун хойноос зүүн урагш чиглэсэн шороон далан бүхий сувгийн үлдэц мэдэгдэнэ. Хэрмийн дунд алсаас харагдах гозгор хадан цохиог нутгийнхан “Чингисийн морины уяа” хэмээн домоглодог.



Өглөгчийн хэрэм нь Монгол улсын нутагт буй эрт цагт хүний гараар бүтээгдсэн хамгийн урт, том хэмжээтэй чулуун хэрэм бөгөөд судлаачид тус хэрмийг нийтийн тооллын X-XI зууны үед анх баригдсан хэмээн үздэг.

Хажуу нуурын буган хөшөө

Буган хөшөө нь хүрэл, түрүү төмөр зэвсгийн үеийн эртний нүүдэлчдийн түүх соёл, шүтлэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, амьтны загварт урлагийн гарал үүсэл, хөгжлийг тодорхойлох хосгүй дурсгал юм.

Хажуу нуурын хоёр буган хөшөө нь Монгол-Өвөр Байгалийн хэмээх сонгодог төрөлд хамаарах бөгөөд эргэн тойронд нь 13 дөрвөлжин булш, нэг хиргисүүртэй цогцолбор байдлаар хадгалагдаж байна.

Зүүн талын хөшөөг элсэн занар чулуугаар үйлдсэн, 2.3 метр өндөр, 0.42 метр өргөн, 0.30 метр зузаан хэмжээтэй. Нүүрэн талд унжлагатай дөрвөн цагирган зүүлт, толь, түүний доогуур хөшөөг ороолгон нарийн бүс, баруун талд

том, жижиг цагирган ээмэг, зүүлт, түүний доогуур гурван буга, ар талд унжлагатай цагирган зүүлт, зүүн талд цагирган ээмэг, зүүлт, дөрвөн бугыг дээш тэмүүлэн дүүлж буйгаар загварчлан дүрсэлсэн.



Хажуу нуурын 2 буган чулуун хөшөө

Баруун талын хөшөө нь боржин чулуугаар үйлдсэн, өндөр нь 2.5 метр, өргөн нь 0.31 метр, зузаан нь 0.41 метр хэмжээтэй. Хөшөөнд долоон бугыг бүх талбайгаар нь хонхойлон цохиж загварчлан сийлсэн нь он цагийн уртад ихэд элэгдэн бүдгэрч, мэдэгдэх төдий болжээ.

Буган хөшөө нь оршуулга, тахилгын зан үйл бүхий хиргисүүр, дөрвөлжин булштай хамт байгуулсан цогцолбор дурсгал бөгөөд судлаачид хөшөөний илэрхийллийг хүнтэй холбон "баатарлаг дайчин эрийн хөшөө", "язгууртан удирдагчийн дүр", "хүний сүнслэг бие дүр" хэмээн үздэг.


Буган хөшөөний амьтны загварт дүрслэл бүхий сонгодог төрлүүдийг Монгол нутагт, тухайлбал Хангай нурууны бүсэд хүрэл зэвсгийн дунд үед үүсч төмөр зэвсгийн түрүү үе (НТӨ XIV-VIII зуун)-д түгэн дэлгэрч, өнөөгийн ОХУ-ын Тува, Байгал нуурын өмнөд бие, Казахстан, Дундад Ази, Оренбург, Умард Кавказ, Эльба мөрний сав хүртэл тархсан болохыг тогтоожээ.

Буган хөшөөг 100 орчим жилийн тэртээгээс судалж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд Евразийн бүс нутагт 1600 орчим буган хөшөө илрүүлсний 1300 гаруй нь Монгол улсын нутагт хамаарна. Хажуу нуурын хоёр буган хөшөө нь уг дурсгалын тархалтын хамгийн зүүн захын дурсгал болж буйгаараа онцлог юм.

Хирст хад

Рашаан хадны цогцолбор дурсгалын хадны зургийн дотроос хамгийн эрт үед холбогдох, хосгүй үнэт дурсгал нь арслан заан, савагт хирсний сийлмэл зураг болно. Энд өргөргийн дагуу 7.6 м сунаж тогтсон гурвалжиндуу хэлбэртэй ургаа хадны зүүн талын 2.6 x 2.0 м хэмжээтэй нар тоссон тэгш гадаргуу дээр нь 3 том амьтны сийлмэл зураг байна. Сүрэглэн явж буй мэт гурван амьтдын

толгойг бүгдийг нь зүүн тийш хандуулан толгойг нь бага зэрэг доош уншуулан, бүх биеийнх нь гадаргуугаар хөвөөлөн цохиж сийлсэн. Судлаачид эдгээр зургийг савагт хирс (Woolly rhinoceros) хэмээн тодорхойлдог бөгөөд хуучин чулуун зэвсгийн дээд үед буюу 35000-12000 жилийн тэртээд холбогдуулан үздэг. Савагт хирс нь дэлхийн эх газрын хойд хэсгийн нутагт оршин байгаад 10 мянга гаруй жилийн өмнө устсан бөгөөд сэрвээний өндөр дунджаар 2 метр, 1500-2000 кг жинтэй байсан гэж үздэг. Хамар дээрээ хоёр эвэртэй, доод талынх нь илүү том, урт, зузаан үс ноосоор хучигдсан арьстай, жижиг чихтэй хүйтэн, сэрүүн уур амьсгалд зохицсон амьтан байжээ.



Савагт хирс

Рашаан хадны чулуун зэвсгийн олон соёлт давхарга бүхий сууринг малтан шинжлэх явцад 1,5 м гүнээс чулуун зэвсгийн хамт савагт хирсний шүд олдсон ба хэдхэн метрийн зайд сүрэглэж явж буй гурван хирсийг бодитой сийлж дүрсэлсэн нь эртний хүний амьдрал, оюун ухааны хөгжил, шүтлэг, хүрээлэн буй байгаль орчны төлөв байдлыг танин мэдэх чухал баримт юм.

Биндэр уул - /Хулдгар хун/ “Монголын нууц товчоон”-ы 117-р зүйлд Тэмүжин Жамух хоёрын анд бололцсон талаар, “Хорхунаг Жубурын хөндийд, Хулдгар хуны өвөрт, Саглагар модны дор” хэмээн өгүүлсэн газар нь одоогийн Биндэр уул юм. Биндэр уулыг хойд талаас нь ажиглахад хошуугаа дэвсэн, хүзүүгээ сунган хэвтэж буй хунтай төстэй хэмээдэг.



Бидэр хошуу (МНТ§88)

Тэмүжин Тайчуудын бариа хорионоос Сорхон шарынхны тусламжтай оргоод ээж, дүү нартайгаа нийлэхээр өвсний налархайгаар мөр мөшгөн хайж явахдаа Химурга горхины Бидэр хошууны Хорчухуй Болдогт, эх дүү нартайгаа уулзсан газрыг өнөөгийн Биндэрийн овоо Рашаан хад орчмын нутаг мөн хэмээн судлаачид үздэг.

Хорхунаг жубур (МНТ§57,104, 115, 116, 117, 201, 206)

“Монголын нууц товчоон”-ны 57-р зүйлд “Амбагай хаан, Хадаан, Хутула хоёрыг нэр зааж илгээснээр, Хамаг Монгол, Тайчууд Ононы Хорхунагийн хөндийд хурж, Хутулыг хаан болгов. Монголын жаргалан нь дэвсэн(бүжиглэн), хуримлан цэнгэх бүлгээ. Хутулаг хан өргөмжлөөд Хорхунагийн саглагар мод тойрон

Хавиргандаа

Хуулга болтол

Өвдгөндөө

Өвчин ортол дэвсэв. Мөн “Монголын нууц товчоон”-ны 117-р зүйлд “Тэмүжин, Жамух нар алтан бүс солилцсон тухай дурьдаад “Хорхунаг жубурын Хулдгар хуны өвөрт, саглагар модноо анд хэмээлдэж амралдаж, хуримлан тойлон жаргалдаж, шөнө хөнжилдөөн хамт хонох бүлгээ” хэмээн өгүүлдэг. Энэхүү Хорхунаг Жубурын хөндий нь одоогийн Хэнтий аймгийн Биндэр, Батширээт, Өмнөдэлгэр сумдын зааг нутагт Биндэрийн овоо, Рашаан хадны өмнүүр 60 гаруй км үргэлжлэх Хурхын хөндий юм. Энэ хөндий нь ус бэлчээр, өвс ургамал сайтай, ан амьтан, араатан жигүүртэн, ой мод, цэцэг, жимс цөм бүрдсэн, нэгэн үед Хамаг Монголын язгууртнуудын үндсэн нутаг нь байжээ. XIII зууны үед Хурхын гол, Жаргалантын голыг нийтэд нь Химурга горхин, Хурхын хөндийн Онон мөрөнд ойр хэсгийг Хорхунаг Жубур гэдэг байсан болов уу хэмээн судлаачид үздэг.

Баянголын амны хүн чулуу

Биндэрийн овооноос Батширээт сумын төв орох замын баруун талд Баянголын аманд шаргал өнгийн боржин чулууг засаж хүний нүүр, биеийн хэсгийг тодорхой дүрсэлсэн хөшөө бий. Хөшөөний өндөр 114 см, өргөн 35 см, зузаан нь 30 см. Хүн чулууг өмнө зүгт харуулан босгожээ. Гадуураа 12.60м х 12м метр хэмжээтэй дугуй



шороон далантай. Шороон далангийн зүүн талд 5 зэл чулууг зүүн тийш цувуулан босгожээ. Хүн чулуунаас зүүн тийш 225м зайд уртрагийн дагуу цувуулан үйлдсэн дөрвөн тахилын хашлага бий.

Бархын Баянголын хүн чулуу

Батширээт сумын нутаг Бархын Баян голын амны эхэнд буй айлын өвөлжөөний хойд талд жижиг судаг дотор хэвтээ байдалтай буй. Цайвар хөх саарал өнгийн нарийн ширхэгтэй боржин чулуугаар хийсэн ба цээжин хэсгээрээ хугарсан, ойр орчимд нь ямар нэгэн тахилын хашлага, зэл чулуу байхгүй. Зөвхөн хүний нүүрний дүрслэлтэй бөгөөд нүд, хамар, ам, хацрын зураас, эрүү нь тод мэдэгдэнэ. Өндөр нь 62 см, өргөн нь 36 см, зузаан нь 26 см хэмжээтэй.



Онон мөрөн

Монголын түүхийн голомт нутгийн нэг Онон мөрний савд болж өнгөрсөн түүхэн үйл явдал нь "Монголын нууц товчоон"-д хамгийн олон бүлэг зүйлд дэлгэрэнгүй бичигдсэн байдаг. *"Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий инү Хоо Марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ, Бурхан халдунаа нутаглаж бүхүйд төрсөн Батачихан ажгуу"* хэмээн "Монголын нууц товчоон" эхэлдэг билээ. Энэ үйл явдлын он цаг нь ойролцоогоор нийтийн тооллын 600 оны үед холбогдоно хэмээн судлаачид үздэг бөгөөд түүнээс хойш 1400 гаруй жилийн турш Онон мөрний нэр огт өөрчлөгдөөгүй өнөөг хүрснийг хожмын түүхэн сурвалжууд гэрчилнэ.



Онон мөрөн

Их Хэнтийн нуруу Бурхан халдун уулын араас Их Давааны гол, Өвөр Өнгөлж хэмээх хоёр жижиг гол нийлэн Онон мөрний эх болно. Түүнчлэн хойд талаас нь Бирьяагийн сардигаас эх авсан горхитой нийлэн Түшлэгт ян, Жинст ян хэмээх уулсын араар Ононгийн халуун рашааныг дайран зүүн зүгт урсах замд Баруун, Зүүн, Дунд Тарсын гол нийлэн их устай болно. Мөн Эг, Барх, Хурх, Шуус, Агац, Хёрхон, Балж зэрэг олон гол цутгаж үндсэн ай савыг нь бүрдүүлнэ. Нийт ай савын талбай нь 96 000 кв км хэмжээтэй. Монгол улсын нутгаар 298 км урсах ба ус нь эрдэсжилт багатай, бохирдолгүй, маш зөөлөн чанартай, голын эх нь адгаасаа 1.100 м өндөрт орших тул урсгал харьцангуй хурдтай.

Онон нь дэлхийн хамгийн том таван мөрний нэг 4400 гаруй км урт ямар нэг хаалт саадгүй урсдаг Амар мөрний эх мөн тул экосистемийг нь хамгаалах асуудал олон улсын анхааралд байдаг.

Ононы цагаан нуур /Их хуралдайн хөшөө/

“Монголын нууц товчоон”-ы 202-р зүйлд “Төдий эсгий туургат улсыг шулуутгаж, (нэгтгэж) барс жил (1206) Ононы тэргүүнээ хурж, есөн хөлт цагаан туг байгуулаад, Чингис хаанд хан цол тэнд өгөв” хэмээн өгүүлдэг. Их Монгол улсыг байгуулсан түүхэн үйл явдал болж өнгөрсөн газар нь Хэнтий аймгийн Биндэр сумын урд Цагаан нуур орчим мөн хэмээн зарим судлаачид үздэг.

Сумын төвөөс урагш 2 км зайд орших Цагаан нуурын хөвөөнөө “Их хуралдайн гэрэлт хөшөө”-г 2003 онд нутгийн уугуул иргэдийн санаачлагаар бүтээн босгожээ.



Онон, Хурхын ус намгархаг газрууд

Биндэр сумын Хурхын хөндийд Булангийн, Биндэрийн, Цагаан, Цэгээн, Батширээт сумын Эгийн хөндийд Цэгээн хоолойн нуур, Баянбүрд, Дуут, Ёлын, Хонхорын, Дадал сумын Галттайн голын хөндийд Их цагаан, Бага цагаан, Наадмын, Онон, Балж голын хооронд Дэлүүн болдогийн Гурван нуур, Агваан хөндийн гурван нуур, Өмнөдэлгэр сумын нутаг Ар нуур, Баян-Адаргын Хүйтний хөндийн зэрэг давсархаг нуурууд, ус намгархаг газрууд олон бий. Эдгээр нуур, ус чийгтэй намгархаг газрууд нь олон зүйлийн усны шувуудын өндөглөн зусдаг үндсэн нутаг юм.



Хурх, Хүйтэнийн голын хөндийн ус, намгархаг газар

Бор булгийн Хүннүгийн дурсгал

Хэнтий аймгийн Биндэр сумын төвөөс зүүн өмнө зүгт 19 км зайд, Онон голын урд бие Баянголын хөндийн зүүн өмнөд хэсэгт оршино. 1991 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хүрээнд хайгуул судалгаа хийж, хүннү булш 141, түрэгийн тахилын байгууламж 7, Монгол гүрний үеийн булш 9, он цаг тодорхойгүй хэд хэдэн булш илрүүлэн, дурсгалт газрын тойм зургийг үйлджээ. Хүннү булшнууд нь уулын арын тэгш талбайд зүүн хойноос баруун өмнө тийш ташуулдсан байдалтай байрлана. Булшнуудын дийлэнх нь дөрвөлжин хэлбэрээр хүрээлж тавьсан чулуун байгууламж, түүний өмнө талд залгуулан байгуулсан урт гонзгой үүдэвчтэй юм. Мөн дугуй болон зууван дөрвөлжин хэлбэрийн булшнууд ч тохиолдох бөгөөд эдгээрийн ихэнх нь үүдэвчтэй булшны баруун зүүн талаар цуварсан маягтай дагуул булшнууд байна. Үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн булшнууд нь хэмжээгээр харилцан адилгүй ба хамгийн том булшны гол байгууламжийн хэмжээ 29.2 x 27.2 м, өнгөн хөрснөөс дээш 0.5 м өндөр ажээ. Бор булагийн амны дурсгал нь Монголд илэрсэн Хүннүгийн язгууртны булш бүхий 7 том оршуулгын газрын нэг бөгөөд одоогоор малтлага судалгаа хийгдээгүй.



Бор булгийн Хүннү булш

Дуурлиг нарсны Хүннүгийн дурсгал

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын төвийн өмнөх дугуйран ургасан нарсан ой дотор Хүннүгийн язгууртны 300 орчим булш тархан байрлах бөгөөд эдгээр булшнууд уг газрын нэрээр алдаршжээ. Анх 1974 онд Х.Пэрлээ, Д.Цэвээндорж нар нээн илрүүлж, 1991 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хүрээнд дурсгалт газрын дэвсгэр зургийг үйлджээ. 2006-2011 онд Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн хүрээнд нарийвчилсан бүртгэл, хайгуул, зураглалын ажил гүйцэтгэж, язгууртны 3 булш, 11 жижиг булш бүрэн хэмжээгээр анх удаа малтан шинжилж, тал нутгийн нүүдэлчдийн соёл, ёс заншил, гадаад харилцааг илтгэх олон шинэ олдвор нээн илрүүлсэн юм.

Дээрх булшны малтлагын үр дүнд Хүннүгийн язгууртны булшны бүтэц зохион байгуулалтын талаар багагүй шинэ мэдээлэл цуглуулснаас гадна морины тоног хэрэгсэл, авсны алтан чимэг, хүрэл дэнгийн цөгц, гүц, хүрэл толь, шувууны дүрстэй чулуун зүүлт, хаш эдлэл, хүрэл болон төмөр тогоо, төмөр шанага, шүүлтүүр, угалзарсан хөөмөл хээтэй бүсний алтан чимэг, гоёмсог хийцтэй шавар ваар зэрэг ховор олдвор эд өлгийн зүйлсийг илрүүлжээ. Түүнчлэн төмөр тогоо, төмөр шүүлтүүр зэрэг олдворууд нь Хүннүгийн дурсгалаас өмнө нь олдож байгаагүй бөгөөд мөн шавар ваарны ёроолд дарсан тамга, хүрэл цөгцөн дотор хадгалагдсан өөхөн тос зэрэг хүннүчүүдийн оюуны болон эдийн соёлыг илтгэх шинэ содон эх хэрэглэгдэхүүн ч цөөнгүй илэрсэн юм.



Дуурлиг нарсны Хүннүгийн язгууртны булш

Энэхүү дурсгал нь одоогоор Монгол нутагт илэрч мэдэгдээд буй Хүннүгийн язгууртны долоон том дурсгалын нэг бөгөөд Хүннү гүрний зүүн жигүүрийг захирч асан язгууртан дээдсийн оршуулга хэмээн үздэг.

“Монгол хатдын өргөө” цогцолбор

Монгол төрийн цэцэн билэгт их хатдын өлгий нутаг, Халхын Сэцэнхан аймгийн Хөвчийн жонон вангийн хошууны нэгэн хэсэг болох Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг Дуурлиг нарсны дэнж хэмээх газар Монгол төрийн үе үеийн түүхийг бүтээлцсэн их хатдад зориулсан хүндэтгэлийн өргөө цогцолборыг 2011 онд барьж байгуулжээ. Энэ нутагт Монголын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагтын хатан Улсын эх дагина Ц.Дондогдулам, Н.Гэнэнпил нар төрж өссөн гэдэг. Монгол хатдын богтаг малгайн хэлбэртэй гол өргөөг тойруулан дөрвөн их суварга, есөн цагаан гэрийг босгожээ. Гол өргөөний хойморт их хатдын сэнтийг урлан залсан байх бөгөөд домогт Алангуа, Өүлэн эх, Бөртэ үжин, Сорхагтани бэхи, Дөргөн хатан, Мандухай сэцэн, Өндөр гэгээний ээж Ханджамц, Галдан бошготын хатан Ану, VIII



Богд хааны хатан Ц.Дондогдулам, Н.Гэнэнпил нарын хөргийг байрлуулж, өргөөний голд есөн хөлт их цагаан тугийг залсан байна.

Хүйтний хөндийн хөшөө

“Монголын нууц товчоо” /МНТ§147,148/-нд өгүүлсэн Чингис хаан, Ван хан хоёр Жамухын эвслийн цэргийг няцаан бутаргасан Хүйтэн хэмээх газар нь өнөөгийн Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутагт орших Хүйтний хөндий мөн хэмээн зарим судлаачид үздэг. 2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн иргэдийн санаачлагаар энэ газарт босгосон дурсгалын хөшөө нь сумын төвөөс баруун урагш 30 орчим км зайтай.

Гэрэлт хөшөөнд “Чингис хааныг дарахаар Жамуха бусадтай эвлэлдэн довтолж ирэх үед Чингис хаан Хүйтэнд тосон байлдаж бут цохих үедээ хүзүүний судсандаа шарх авч ихэд зовсон бөлгөө” хэмээн монгол бичгээр сийлсэн байна.



5. Судалгааны ажлын товч үр дүн

“Эм Си Пи Си Жи Ар” ХХК нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй хатуу хучилттай авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү ажлын хүрээнд тус компани нь “Монгол улсын иргэний хууль” болон “Соёлын өвийн хамгаалах тухай хууль”-ийн холбогдох заалтуудыг үндэслэн ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй ажил гүйцэтгэх №Б/2021-34 тоот гэрээ байгуулсан юм. Тус гэрээний дагуу Археологийн хүрээлэнгийн судлаачид Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй 115 км (А хувилбар) авто замын трассын дагуу археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.

Археологийн дурсгалыг бүртгэж баримтжуулах хайгуул судалгааг Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын урд болон хойд талаас Биндэр сумын төв болон сумын төвийн урд Онон голын бетонон гүүр хүртэл тавихаар төлөвлөж буй 115 км авто зам (замын эхлэл цэгээс төгсгөл цэг хүртэл)-ын трассын дагуу энгийн хайгуулын арга зүйг баримтлан хийж гүйцэтгэв.

Хайгуул судалгааны явцад замын трассын дагуу нийт 41 дурсгал илрүүлж бүртгэн баримтжуулав. Эдгээрийг Дурсгал-01, 02... хэмээн археологийн хайгуул судалгааны арга зүйн дагуу тэмдэглэсэн болно.

Замын трассын дагуу илрүүлэн бүртгэж баримтжуулсан нийт дурсгалууд нь хатуу хучилттай зам тавихаар төлөвлөж буй замын трассын голын шугамаас 0-154 м зайд байрлана. Эдгээрээс,

28 дурсгал (*Дурсгал-02, 03, 08, 09, 10, 11, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 33, 34, 35, 36, 37*) нь замын трассын гол шугамаас 0-50 м хүртэлх зайд,

5 дурсгал (*Дурсгал-01, 12, 13, 31, 32*) нь 50-100 м хүртэлх зайд,

8 дурсгал (*Дурсгал-04, 05, 06, 07, 38, 39, 40, 41*) нь 100-154 м хүртэлх зайд тус тус байрлаж байна.

Харин Дурсгал-41 хэмээн тэмдэглэгдсэн дурсгал нь Хурх багийн төвөөс Үзүүр цохио (Рашаан хад, Биндэрийн овоо, Биндэр уулын энгэр бэл, Өглөгчийн гол орчмоор) хүртэлх өргөн талбайг хамран тархсан чулуун зэвсгийн соёлт давхаргатай болон ил суурин хосолсон дурсгалт газар юм. Дурсгалын хамрах хүрээг нарийвчлан тогтоогоогүй боловч 10 км-ийн голч бүхий өргөн уудам талбайд тархсан болох нь мэдэгддэг.

Хайгуул судалгаагаар илрүүлсэн дурсгалуудыг холбогдох он цагийн хамаарлаар ангилвал, дээд палеолитын эхнээс неолитын үеийг хүртэлх чулуун зэвсгийн олдвор бүхий дурсгалт газар-1, хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр-6, хүрэл зэвсгийн үеийн дугуй дарааст булш-6, хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш-14, эртний улсуудын үед хамаарах тахилын онгон-5, монгол булш-1, хөшөө чулуу-1, хээтэй хашлага-1, туурь-2, шороон байгууламж-1, он цаг тодорхойгүй чулуун байгууламж-3 хэмээн урьдчилсан байдлаар тодорхойлов.

Хайгуул судалгааны явцад гадаад зохион байгуулалтаар нь холбогдох он цагийг тодорхойлох боломж хомс дурсгал 3 бий. Эдгээр нь дурсгал-02, 14, 35 болно. Монгол орны нутаг дэвсгэрээс гадаад зохион байгуулалт нь алдагдсан булш оршуулга болон тахил тайлгын байгууламжууд нэлээд олддог. Эдгээр нь ямар ч болов хүний гараар бүтээгдсэн дурсгал юм. Ийм дурсгалын холбогдох он цагийн асуудлыг малтлага судалгаа хийснээр илүү тодруулах боломж бүрддэг.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум руу тавихаар төлөвлөж буй 115 км (А хувилбар) хатуу хучилттай авто замын трассын дагуу илрүүлсэн дурсгалууд нь Монголын нэн эрт, дундад болон хожуу үеийн түүхэнд холбогдох түүх, соёлын биет өв юм. Тиймээс, цаашид авто зам барих бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө шууд нөлөөллийн бүсэд хамаарах (трассын дагуу өгөгдсөн шугамаас хоёр тийш тус бүр 50 метр зайд) дурсгалуудыг мэргэжлийн байгууллагаар малтан судлуулж чөлөөлүүлэх шаардлагатай болно (Хүснэгт.1-ээс харна уу). Мөн замын трассын дагуух шугамаас 50 м-ээс илүү зайд байх дурсгалууд нь шууд нөлөөллийн бүсэд хамаарахгүй боловч замын хажуугийн далан хаалт, ус зайлуулах суваг барих болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөндөгдөхөд хүрвэл малтан судлуулах ажилд мөн адил хамаарна.

Замын трассын дагуу илэрсэн дурсгалуудын зайн хэмжээ Хүснэгт.1.

№	50 м хүртэл	50-100 м хүртэл	100 м-ээс илүү
1	Дурсгал-02, 03, 08, 09, 10, 11, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 33, 34, 35, 36, 37.	Дурсгал-01, 12, 13, 31, 32.	Дурсгал-04, 05, 06, 07, 38, 39, 40.
2	Дурсгал-41. Бүх хэмжээнд хамаарна.		

Цэвээндорж, Цогтбаатар, 1993 – Д. Цэвээндорж, Б. Цогтбаатар. Монгол-Японы хамтарсан "Гурвангол" төслийн 1993 оны археологийн хээрийн шинжилгээний тайлан. Улаанбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

Цэвээндорж, Цогтбаатар, 1993 – Д. Цэвээндорж, Б. Цогтбаатар. Монгол-Японы хамтарсан "Гурвангол" төслийн 1993 оны археологийн хээрийн шинжилгээний тайлан. Улаанбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

Цэвээндорж, Д. Баяр, Б. Цогтбаатар, 1993 - Д. Цэвээндорж, Д. Баяр, Б. Цогтбаатар. Монгол-Солонгосын "Дорнод Монгол" төслийн 1993 оны хээрийн шинжилгээ. //Монгол-Солонгосын хамтарсан Эрдэм шинжилгээ-2. Сүүл, 14-35, 119-124.

Цэвээндорж, Д. Баяр, Б. Цогтбаатар, 1994 - Монгол-Солонгосын "Дорнод Монгол" төслийн 1994 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. //Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ-3. Сүүл, 46-60, 125-132.

Цэвээндорж, Д. Баяр, Б. Цогтбаатар, 1995 - Монгол-Солонгосын "Дорнод Монгол" төслийн 1995 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Сүүл.

Цэвээндорж нар, 2003 - Д. Цэвээндорж, Д. Баяр, Б. Цогтбаатар, Ч. Амартүвшин, Д. Болдхуяг, Ж. Гантулга, Б. Эрдэнэ. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хөдөө арал орчимд хийсэн археологийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

Erdelyi, 1977 – I. Erdelyi. Recently found relics of Turkic stone sculpture from the territory of the Mongolian People's Republic // Arts of the Eurasian steppelands. Edited by Philip Denwood. A Colloquy held 27-29 June 1977. Colloquies on Art and Archaeology in Asia No.7. University of London. Percival David Foundation of Chinese Art. School of Oriental and African Studies. 203-217.

Erdelyi, Tseveendorj, 1994 - I. Erdelyi, D. Tseveendorj. The Latest results from Mongolian-Hungarian joint Archaeological research 1986-1989. //Kulonlenyomat az archaeologiai erasito. 120 Kotet 1-2, Szamobol, Budapest.

Gurvan Gol, 1990 - A report on the joint investigation under the Mongolian and Japanese (Initial year), Tokyo.

Gurvan Gol, 1994 - A report on the joint investigation under the Mongolian and Japanese (1991-1993), Tokyo.

Hayashi, Izuho et al., 2007 - Hayashi Kazuhiro, Izuho Masami, Yamaoka Takuya, Tsogtbaatar Batmunkh.